



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Б.ЭНХБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2022. 10. 28 № 01/ ᠑᠒14
танай 2022. 09. 29 -ны № 33 -Т

Асуулгын хариу
хүргүүлэх тухай

Танаас 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр ирүүлсэн татварын маргаан шийдвэрлэлтийн талаарх асуулгатай танилцлаа.

Асуулгад дурдсан Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилсон шийдвэр, Маргаан таслах зөвлөлийн ажиллах журам, гомдлын шийдвэрлэлтийн судалгаа, "Петрочайна дачин тамсаг" ХХК-д холбогдох татварын улсын байцаагчийн 0297791 тоот шийтгэлийн хуудас, Маргаан таслах зөвлөлийн тогтоол, хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг Татварын ерөнхий газрын даргаас гаргуулан хүргүүлж байна.

Эдгээр материалыг хүргүүлж байгаатай холбогдуулан Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд заасан нууцлалын баталгаатай холбоотой зохицуулалтыг анхаарахыг Танаас хүсье.

Хавсралт ¹⁵⁰ хуудас

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9762005543



САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ж.ГАНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Улаанбаатар хот, ЧД 4-р хороо,
Бага тойруу /15160/, С.Данзангийн гудамж 4А.
Утас: (976-11) 32-13-09, E-mail: info@mta.gov.mn

2022.10.28 № 01/1338
талай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяраас 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 33 дугаар албан бичгээр ирсэн асуулгын хариуг тус газрын 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 02/2131 дүгээр албан бичгээр Танд хүргүүлсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг явуулах хүсэлтийн дагуу хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1: УИХ-ын гишүүн Б.Энхбаярын асуулгын тухай, асуулга болон хариу тайлбар, 5 хуудас

Хавсралт 2: 2016 оноос хойшхи маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилсон Сангийн сайдын тушаал, Татварын ерөнхий газрын даргын тушаалууд, 17 хуудас;


Хавсралт 3: Засгийн газрын 2009 оны 22, 2019 оны 466 дугаар тогтоолоор батлагдсан "Маргаан таслах зөвлөлийн ажиллах журам" 18 хуудас

Хавсралт 4а: 100 сая төгрөгөөс дээш төлбөрийн дүнтэй хяналт шалгалтын шийдвэрийн нэгтгэл (Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 болон 47 дугаар зүйлийн 47.13-ыг тус тус үндэслэн нийт 1123 татвар төлөгчид хамаарах судалгааг шийдвэрийн дугаараар) 19 хуудас

Хавсралт 4б: 100 сая төгрөгөөс дээш төлбөрийн дүнтэй татварын маргаантай хяналт шалгалтын шийдвэрлэлтийн нэгтгэл (Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 болон 47 дугаар зүйлийн 47.13-ыг тус тус үндэслэн нийт маргаан үүсгэсэн 279 татвар төлөгчид хамаарах шийдвэрлэлтийн явцын судалгааг шийдвэрийн дугаараар) 67 хуудас

Хавсралт 5: "Петрочайна дачин тамсаг" ХХК-д холбогдох татварын улсын байцаагчийн 210297791 тоот шийтгэлийн хуудас, дагалдах тэмдэглэлүүд, баримт материалууд, хуралдааны тэмдэглэл, Маргаан таслах зөвлөлийн шийдвэрлэсэн тогтоол, 57 хуудас

ДАРГА



Б.ЗАЯАБАЛ

151643100

Татварын ерөнхий газрын 2022 оны дүгээр сарын
20-ний өдрийн дүгээр албан бичгийн хавсралт

УИХ-ЫН ГИШҮҮН Б.ЭНХБАЯРЫН
АСУУЛГЫН ТУХАЙ

Асуулга 1. Татварын маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрүүд (2016 оноос хойш өнөөдрийн байдлаар):

Татварын ерөнхий хуулийн 46, 47 дугаар зүйлээр маргаан таслах зөвлөл, түүнд гомдол гаргах, шийдвэрлэх харилцааг зохицуулсан. Маргаан таслах зөвлөл нь төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 9 эсхүл 11 хүний бүрэлдэхүүнтэй дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд хууль тогтоомжийн хүрээнд хамтын шийдвэр гаргадаг, хараат бус бие даасан институт юм.

Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.9-д заасны дагуу аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон даргыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, Татварын ерөнхий газрын дэргэдэх маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон даргыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус томилж чөлөөлнө.

Сангийн сайдын тушаалаар 2016 оноос хойш хугацаанд Татварын ерөнхий газрын дэргэдэх маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 4 удаа, Татварын ерөнхий газрын даргын тушаалаар Нийслэлийн татварын газрын дэргэдэх маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 9 удаа, 21 аймгийн татварын хэлтсийндэргэдэх маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 удаа тус тус томилсон шийдвэрүүд гарсан болно. (Хавсралт-2).

Асуулга 2. Татварын гомдол маргаан үүсгэсэн болон шийдвэрлэсэн байдал, шийдвэрлэхэд үндэслэл болгодог дүрэм журмууд:

Татварын ерөнхий хуулийн арван дөрөвдүгээр бүлгийн 81 зүйлийн 81.1-д заасны дагуу татварын алба болон татварын улсын байцаагчийн гаргасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад шийдвэрийн талаар татвар төлөгч нь захиргааны журмаар дараах харьяаллаар гомдол гаргаж, учирсан хохирлоо төлүүлэх эрхтэй. Тус хуулийн 81.1.1-д татварын улсын байцаагчийн үйлдсэн татварын актаас бусад шийдвэртэй холбогдсон гомдлыг тухайн байцаагчийг шууд харьяалах татварын албаны даргад, 81.1.3-д татварын улсын байцаагчийн үйлдсэн татварын акттай холбогдсон гомдлыг харьяаллын дагуу маргаан таслах зөвлөлд, 81.1.4-д маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй холбогдсон гомдлыг шүүхэд тус тус гаргана гэж зохицуулсан байна.

Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.26-д "татварын акт" гэж татварын улсын байцаагчийн үйлдсэн нөхөн ногдуулалтын акт, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт, татварын буцаан олголтын актыг гэж, 46 дугаар зүйлийн 46.1-д "Татварын албаны дэргэд татвар төлөгчөөс энэ хуулийн 6.1.26-д заасан татварын акттай холбогдуулан гаргасан гомдол, Захиргааны ерөнхий хуулийн 94.2-т заасан хүсэлтийг хяналт шийдвэрлэх чиг үүрэг бүхий татварын маргаан таслах зөвлөлийн ажиллагс" гэж тус тус заасан.

Энэ заалтын дагуу Маргаан таслах зөвлөлийн татварын улсын байцаагчийн үйлдсэн зөвхөн татварын актад холбогдуулан гаргасан гомдол, татварын актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг сэргээхтэй холбогдсон хүсэлтийг хянан шийдвэрлэдэг.

Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагаанд 2016 - 2019 оны татварын жилд хүчин төгөлдөр мөрдөж байсан Татварын ерөнхий хууль (2008 он)-ийн 19 дүгээр зүйлийн 19.3, 42 дугаар зүйл болон Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 22-дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам"-ыг, 2020 оны татварын жилээс шинэчлэн баталсан Татварын ерөнхий хууль (2019 он)-ийн 46, 47 дугаар зүйл болон Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 466 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Маргаан таслах зөвлөлийн ажиллах журам"-ыг тус тус баримтлан ажилладаг болно. (Хавсралт-3)

Асуулга 3. 100 сая төгрөгөөс дээш дүнтэй татварын актууд, тэдгээрийн шийдвэрлэлт, хэрэгжилтийн байдлыг 2016 оноос хойш өнөөдрийн байдлаар дэлгэрэнгүйгээр:

Татварын алба нь татвар төлөгчийн татварын хууль тогтоомжид заасны дагуу төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлж, татвараа хугацаанд нь төлсөн эсэхэд хяналт тавьж, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хариуцлага ногдуулах арга хэмжээг 2016 ондоос 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд Татварын ерөнхий хууль (2008 он)-ийн дагуу, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020.01.01-ний өдөр хүртэл хугацаанд Зөрчлийн тухай хууль (2017 он)-ийн дагуу, 2020.01.01-ний өдрөөс одоог хүртэл Татварын ерөнхий хууль (2019 он)-ийн дагуу авч, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Татварын албанаас 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 09 дүгээр сарыг дуустал хугацаанд нийт 27877 татвар төлөгчийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд татварын хяналт шалгалт хийж, татварын улсын байцаагчийн актаар болон шийтгэлийн хуудсаар 23249 татвар төлөгчид хамаарах 34.7 их наяд төгрөгийн зөрчил илрүүлэн, 2.5 их наяд төгрөгийн төлбөр ногдуулсан ба 4628 татвар төлөгчид татварын хууль тогтоомжийг зөрчсөн зөрчил илрээгүй тул илтгэх хуудас үйлдсэн байна. Татварын хяналт шалгалтыг хийсэн татвар төлөгчийн тоо болон зөрчилтэй, зөрчилгүй шийдвэрлэсэн мэдээг Хүснэгт 1-ээс харна уу.

Хүснэгт-1

(тэрбум төгрөг)

Он	Шалгасан татвар төлөгчийн тоо	Үүнээс:		Төлбөрийн дүн
		Зөрчилтэй	Зөрчилгүй	
2016	5282	4237	1045	82.6
2017	4968	4203	765	167.0
2018	6207	5149	1058	876.7
2019	5405	4382	1023	182.2
2020	2338	1858	480	767.0
2021	2632	2446	186	254.5
2022.09	1045	974	71	171.6
Нийт	27877	23249	4628	2501.8

Татварын хяналт шалгалтад 2016-2019 онд 21862 татвар төлөгчийг хамруулсан бол 2020-2022 онд татварын төлөгчийн татварын эрсдэлд үндэслэн тодорхойлж 6015 татвар төлөгчийг татварын хяналт шалгалтад хамруулсан ба

АТЭС
60978

эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үр дүнд хяналт шалгалтад хамрагдах татвар төлөгчийн тоо буурч, илрүүлсэн зөрчил, ногдуулсан төлбөрийн хэмжээ өссөн мэдээ гарч байна.

Татварын ерөнхий хууль (2019 он)-ийн 41 дүгээр зүйлийн "41.4-т "Татварын алба эрсдэлд, эсхүл татвар төлөгчийн хүсэлтэд үндэслэн татвар төлөгчийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг хянан шалгана." гэж заасны дагуу их өгөгдлийн санг үүсгэн татвар төлөгчийн эрсдэлийн үнэлгээг тооцож, зөвхөн эрсдэл бүхий татвар төлөгчдөд татварын хяналт шалгалт явуулж байна. Эдийн засгийн салбарын ангиллаарх татвар төлөгчдийн судалгаа, логистик регрессийн шинжилгээ, харилцан хаймааралтай татвар төлөгчдийн хооронд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний шинжилгээ, өндөр орлоготой иргэдийн судалгаа, мэдээллийн санд тулгуурласан татварын тайлангийн боловсруулалтын шинжилгээ зэрэгт үндэслэн эрсдэл тооцож, эрсдэл өндөртэй татвар төлөгчийг татварын хяналт шалгалтанд хамруулж байна.

Асуулгад дурдсан 2016 - 2022 оны 09 сарын байдлаарх нийт 27877 татвар төлөгчөөс 100 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй татварын хяналт шалгалтаар ногдуулсан төлбөртэй 1123 татвар төлөгч байна. (Хавсралт-4а)

Татварын ерөнхий хууль (2008 он)-ийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасныг үндэслэн 2016.01.01-нээс 2017.07.01-ныг хүртэлх хугацаанд 146 татвар төлөгчид татварын хяналт шалгалт хийж 1152.8 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 144.5 тэрбум төгрөгийн төлбөр ногдуулж, татварын улсын байцаагчийн акт, Зөрчлийн тухай хууль (2017 он)-ийн дагуу 2017.07.01-нээс 2020.01.01-ныг хүртэлх хугацаанд 365 татвар төлөгчид татварын хяналт шалгалт хийж 9321.8 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 996.3 тэрбум төгрөгийн төлбөр бүхий шийтгэлийн хуудас, Татварын ерөнхий хууль (2019 он)-ийн 42 дугаар зүйлийг үндэслэн 2020.01.01 нээс 2022.09.30 дуусталх хугацаанд 612 татвар төлөгчид татварын хяналт шалгалт хийж 13,588.4 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 1,175.6 тэрбум төгрөгийн төлбөр бүхий нөхөн ногдуулалтын актыг тус тус үйлдсэн байна. (Хүснэгт-2)

Хүснэгт 1-2

(тэрбум төгрөг)

Хамрах хугацаа	Үзүүлэлт	Акт	Шийтгэлийн хуудас	Нөхөн ногдуулалтын акт	Төлбөрийн дүн
2016.01.01-2017.07.01	Татвар төлөгчийн тоо	146			146
	Зөрчлийн дүн	1152.8			1152.8
	Төлбөрийн дүн	144.5			144.5
2017.07.01-2020.01.01	Татвар төлөгчийн тоо		365		365
	Зөрчлийн дүн		9321.8		9321.8
	Төлбөрийн дүн		996.3		996.3
2020.01.01-2022.09.30	Татвар төлөгчийн тоо			612	612
	Зөрчлийн дүн			13588.4	13588.4
	Төлбөрийн дүн			1175.6	1175.6
НИЙТ	Татвар төлөгчийн тоо	146	365	612	1123
	Зөрчлийн дүн	1152.8	9321.8	13588.4	24063.0
	Төлбөрийн дүн	144.5	996.3	1175.6	2316.6

Дээрх 100 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 1123 татвар төлөгчөөс 844 татвар төлөгч нь татварын улсын байцаагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, 279 татвар

төлөгч нь татварын улсын байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрч Татварын ерөнхий хууль (2019 он)-ийн 43 зүйлийн 43.1-д заасны дагуу маргаан таслах зөвлөл болон захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргасан байна. Маргаан таслах зөвлөл болон Захиргааны хэргийн шүүхийн шатанд 182 татвар төлөгчийн гомдлыг эцэслэн шийдвэрлэсэн ба одоогийн байдлаар эцэслэн шийдвэрлэгдээгүй 97 татвар төлөгчийн гомдол маргаан таслах зөвлөл болон Захиргааны хэргийн шүүхэд хянагдаж байна. Маргаан үүсгэсэн 279 татвар төлөгчийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг (Хавсралт-4б)-д тусгасан болно.

Асуулга 4. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д тавьсан татварын акт, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх хуралдааны тэмдэглэлүүд болон гарсан шийдвэрүүд:

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь газрын тосны хайгуул хийх, олборлох, боловсруулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг.

Татварын ерөнхий газрын Улсын төсвийн орлого хяналтын газрын татварын улсын байцаагчид 2013-2017 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд 2018 онд татварын хяналт шалгалт хийж, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210297791 тоот шийтгэлийн хуудсаар 3,601.4 тэрбум төгрөгийн зөрчилд нийт 312.1 тэрбум төгрөгийн төлбөр ногдуулсан.

Татвар төлөгчөөс шийтгэлийн хуудсыг эс зөвшөөрч 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Татварын ерөнхий газрын доргодох Татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан ба маргаан таслах зөвлөлөөс албан бичгээр “Маргаан таслах зөвлөлөөр шийдвэрлэгдсэн асуудлаар дахин төлбөр ногдуулж байгаа нь Татварын ерөнхий хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан татвар төлөгчийн эрх, хууль ёсны эрх ашгийг хүндэтгэх зарчмыг хэрэгжүүлээгүй гэж үзэх үндэслэлтэй байна. Иймд дээрх шийтгэлийн хуудсаар ногдуулсан төлбөрийг дахин нягтлан үзэж “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний дагуу шийдвэрлэнэ үү” гэх асуудлыг Татварын ерөнхий газарт ирүүлсэн.

Татварын алба маргаан таслах зөвлөлөөс ирүүлсэн асуудлыг судлан үзэхэд, Гадаад харилцааны яамнаас авсан тодорхойлолтоор “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” нь Монгол Улсын Засгийн газар болон хуулийн этгээдийн хооронд байгуулсан иргэний эрх зүйн харилцаанд хамаарах гэрээнд хамаарах гэрээ тул Монгол Улсын олон улсын гэрээ гэж үзэх үндэслэлгүй. Хуулиар ногдуулсан татварыг хөнгөлөх, чөлөөлөх асуудал нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал тул Монгол Улсын Засгийн газартай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээгээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүй, шийтгэлийн хуудастай холбогдох гомдлыг Татварын албаны удирдлага хянан шийдвэрлэх эрх зүйн үндэслэлгүй” гэх хариуг 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/1385 дугаар албан бичгээр Маргаан таслах зөвлөлд хариу хүргүүлсэн байна.

Маргаан таслах зөвлөл тус гомдлыг хянан хэлэлцээд Татварын ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.11.2-д заасан “гомдлын нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай, асуудлыг дутуу шийдвэрлэсэн бөгөөд нэмж тодруулах зүйлийн цар хүрээ нь маргаан таслах зөвлөлийн магадлан судлах боломжоос хэтэрсэн” гэх үндэслэлээр 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 07 дугаар тогтоолоор маргаан бүхий шийтгэлийн хуудсыг түдгэлзүүлж, дахин шалгуулахаар дээд шатны татварын албанд буцааж шийдвэрлэсэн байна. Татварын ерөнхий

газрын Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийн дагуу тодруулах шаардлагатай асуудлуудыг дахин хянан үзэж хуулийн дагуу хугацаанд нь Маргаан таслах зөвлөлд буцаан хүргүүлэхээр ажиллаж байна. (Хавсралт-5)

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



0000001

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Татварын ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

Нэг. Гааль, татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийг
дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Зөвлөлийн дарга - Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Гишүүд

- Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;
- Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга;
- Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга;
- Сангийн яамны Нягтлан бодох бүртгэл, бодлогын газрын ахлах мэргэжилтэн /нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт хариуцсан/;
- Гааль, татварын ерөнхий газрын Татварын асуудал эрхэлсэн дэд дарга;
- Гааль, татварын ерөнхий газрын Стратеги хөгжлийн газрын дарга;
- Гааль, татварын ерөнхий газрын Орлогын газрын дарга;
- Гааль, татварын ерөнхий газрын Хууль, эрх зүйн газрын дарга;
- Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн мэргэшсэн нягтлан бодогч.

Нарийн бичгийн
дарга

-Гааль, татварын ерөнхий газрын Хууль, эрх зүйн газрын байцаагч, мэргэшсэн нягтлан бодогч

Хоёр. Гааль, татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд Хуралдсан цаг тутамд 25000 /хорин таван мянган/ төгрөгийн хөлс олгохыг Гааль, татварын ерөнхий газар /С.Пүрэв/-т зөвшөөрсүгэй.

000127



0000002

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Татварын ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дах хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

Нэг. Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийг дараах
бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

- | | |
|----------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Зөвлөлийн дарга | - Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга |
| Гишүүд | - Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга;
- Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга;
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга;
- Татварын ерөнхий газрын дэд дарга;
- Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга;
- Татварын ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга;
- Татварын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга;
- Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын гүйцэтгэх захирал;
- Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн мэргэшсэн нягтлан бодогч /удирдах зөвлөлийн гишүүн/; |
| Нарийн бичгийн дарга | Татварын ерөнхий газрын Хуулийн хэлтсийн байцаагч, мэргэшсэн нягтлан бодогч |

Хоёр. Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цаг тутамд 25000 /хорин таван мянган/ төгрөгийн хөлс олгохыг Татварын ерөнхий газар /Л.Зориг/-т зөвшөөрсүгэй.

Гурав. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн тушаалыг хүчингүй болсонд тооцсугай."



Б.НОЙЖИЛСҮРЭН

000082



0000003

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Маргаан таслах зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

1. Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх
Маргаан таслах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай:

Зөвлөлийн дарга - Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын
дарга;

Гишүүд

- Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга;
- Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга;
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга;
- Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга;
- Татварын ерөнхий газрын дэд дарга;
- Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын дарга;
- Татварын ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга;
- Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн гүйцэтгэх захирал;
- Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн мэргэшсэн нягтлан бодогч /удирдах зөвлөлийн гишүүн/;

Нарийн бичгийн
дарга, гишүүн

- Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын татварын улсын байцаагч, мэргэшсэн нягтлан бодогч.

2. Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх
Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цаг тутамд 25000 /хорин таван
мянган/ төгрөгийн хөлс олгохыг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т
зөвшөөрсүгэй.

976015

0000004



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Маргаан таслах зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

1. Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх
Маргаан таслах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай:

Дарга:	Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга;
Гишүүд:	Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга;
	Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга;
	Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга;
	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга;
	Татварын ерөнхий газрын дэд дарга;
	Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын дарга;
	Татварын ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга;
	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн гүйцэтгэх захирал;
	Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүн, мэргэшсэн Нягтлан бодогч;

Нарийн бичгийн дарга, гишүүн:

Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын татварын улсын байцаагч, мэргэшсэн нягтлан бодогч.

2. Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх
Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цаг тутамд 25,000 /хорин таван мянган/ төгрөгийн хөлс олгохыг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т зөвшөөрсүгэй.

САНГИЙН ЯАМНЫ АРХИВ	
ХУУЛБАР ҮНЭН	
Бүртгэлийн №	8763000302
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга	
Архивын эзэлэгч	<i>[Signature]</i>
Төрийн хуудас	2022 он 04 сар 04 өдөр

0000005



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Нийслэлийн татварын газрын дэргэдэх
Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчилэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Татварын ерөнхий хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.6.4, 42 дугаар зүйлийн 42.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн татварын газрын дэргэдэх "Маргаан таслах зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг дор дурьдсанаар шинэчилэн баталсугай.

Зөвлөлийн дарга:

Татварын ерөнхий газрын Дотоод аудитын газрын дарга

Гишүүд:

Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын ажлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/;

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн хэлтсийн ажлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/;

Татварын ерөнхий газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн;

Улсын төсвийн орлого, хяналтын газрын Эрсдэл, статистикийн хэлтсийн дарга;

Нийслэлийн татварын газрын Татвар төлөгчтэй харилцах хэлтсийн дарга;

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Нягтлан бодох бүртгэлийн арга зүйн хорооны дарга /зөвшилцсөнөөр/;

Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчдын зөвлөл нийгэмлэгийн мэргэшсэн нягтлан бодогч /зөвшилцсөнөөр/.


Нарийн бичгийн дарга:

Нийслэлийн татварын газрын Захиргааны хэлтсийн магадлагч-татварын улсын байцаагч, мэргэшсэн нягтлан бодогч

2. Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цаг тутамд 20,000 /хорин мянга/ төгрөгийн хөлс олгохыг Нийслэлийн татварын газар /Д.Мөнх-Учрал/-т зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Маргаан таслах зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг шинэчилэн батлах тухай Татварын ерөнхий газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/141 дүгээр тушаал хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙН
ОРЛОН ГҮЙЦЭТ



0000005

Tushaal-2016



**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

**Нийслэлийн татварын газрын дэргэдэх
Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.6.4, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурьдсанаар шинэчлэн баталсугай.

Зөвлөлийн дарга: Татварын ерөнхий газрын дэд дарга

Гишүүд:


Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын СТОУС хариуцсан ахлах мэргэжилтэн
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн төсвийн ерөнхий мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
Улсын төсвийн орлого хяналтын газрын Эрсдэл, статистикийн хэлтсийн дарга
Татварын ерөнхий газрын Хуудийн хэлтсийн мэргэжилтэн
Нийслэлийн татварын газрын Татварын орлогын хэлтсийн дарга
Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Нягтлан бодох бүртгэлийн сургалт, арга зүй хариуцсан дэд захирал
Монголын мэргэшсэн үнэлгээндийн институтын төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Нийслэлийн татварын газрын Захиргааны хэлтсийн магадлагч-татварын улсын байцаагч, мэргэшсэн нягтлан бодогч

Хоёр. Нийслэлийн татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цаг тутамд 20,000 /хорин мянга/ төгрөгийн хөлс олгохыг Нийслэлийн татварын газар /Д.Мөнх-Учрал/-г зөвшөөрсүгэй.

Гурав. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай" Гааль, Татварын ерөнхий газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/41 дүгээр тушаал, 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийг А/19 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Л.ЗОРИГ

0000007



**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

**Нийслэлийн татварын газрын дэргэдэх
Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.6.4 дэх заалт, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурьдсанаар шинэчлэн баталсугай.

Зөвлөлийн дарга Гишүүд	Дотоод аудитын газрын дарга Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын СТОУС хариуцсан ахлах мэргэжилтэн Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Төрийн сангийн төсвийн ерөнхий мэргэжилтэн Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын татварын улсын байцаагч Нийслэлийн татварын газрын татварын орлогын хэлтсийн дарга Улсын төсвийн орлого хяналтын газрын Эрсдэл-статистикийн хэлтсийн дарга Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын нягтлан бодох бүртгэлийн сургалт, арга зүй хариуцсан дэд захирал Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын төлөөлөл
Нарийн бичгийн дарга	Нийслэлийн татварын газрын Захиргааны хэлтсийн татварын улсын байцаагч, магадлагч

2.Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цаг тутамд 20000 (хорин мянга) төгрөгийн хөлс олгохыг Нийслэлийн татварын газар /Д.Мөнх-Учрал/-т зөвшөөрсүгэй.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн "Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" А/29 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАНДАНБАТ



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.6.4 дэх заалт, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурьдсанаар шинэчлэн баталсугай.

Зөвлөлийн дарга: Татварын ерөнхий газрын Дотоод аудитын газрын дарга

Гишүүд: Сангийн ламны Нягтлан бодох бүртгэлийн газрын СТОУС хариуцсан ахлах мэргэжилтэн
Улсын төсвийн орлого, хяналтын газрын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн дарга
Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын татварын улсын ахлах байцаагч
Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Төрийн сангийн газрын ахлах мэргэжилтэн
Нийслэлийн татварын газрын Захиргааны хэлтсийн дарга
Монголын маргацсан нягтлан бодогчдын институтын Сонгинохайрхан салбарын дарга Х. Нямбаяр /зөвшилцсөнөөр/
Монголын мэргэцсэн үнэлгээчдийн институтын төлөөлөл
Ё. Наранбилэг /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:


Нийслэлийн татварын газрын Захиргааны хэлтсийн Магадлагч-татварын улсын байцаагч

2. Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цаг тутамд 20000 /хорин мянга/ төгрөгийн хөлс олгохыг Нийслэлийн татварын газрын дарга /Д.Мөнх-Учрал/-д зөвшөөрсүгэй.

3. Татвар төлөгчийн өргөдөл, гомдлыг хууль, журамд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэж байхыг Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөл /Д. Сайханчулуун/-д үүрэг болгосугай.

4. Эцэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн "Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай" А/25 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГН
БӨГӨӨД ДЭД ДАРГА



Б.ЗАЯАВАЛ

2019 тушаал

0000005



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот.

Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.6.4, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Зөвлөлийн дарга: Татварын ерөнхий газрын Дотоод аудитын газрын дарга

Гишүүд:
Татварын ерөнхий газрын Татварын орлогын газрын Татварын улсын ахлах байцаагч
Улсын төсвийн орлого хяналтын газрын Эрдэс баялаг, олон улсын татварын хэлтсийн дарга
Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын татварын улсын ахлах байцаагч
Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Төрийн сангийн газрын ахлах мэргэжилтэн
Нийслэлийн татварын газрын Захиргааны хэлтсийн дарга
Монголын мэргэшсэн нягтлан бодогчийн институтын Сонгинохайрхан салбарын дарга Х.Нямбаяр /зөвшилцсөнөөр/
Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын төлөөлөл Е.Наранбилэг /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга: Нийслэлийн татварын газрын Захиргааны хэлтсийн Магадлагч-татварын улсын байцаагч

2. Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цаг тутамд 20000 (хорин мянга) төгрөгийн хөлс олгохыг Нийслэлийн татварын газрын дарга /Д.Мөнх-Учрал/-д зөвшөөрсүгэй.

3. Татвар төлөгчийн өргөдөл гомдлыг хууль, журамд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэж байхыг Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөл /Д.Сайханчулуун/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/45 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
БОГООД ДЭД ДАРГА

Б.ЗЛЯАБЛГ

0000016



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН АЛБАН
ДЭД ДАРГЫН АЛБАН ГҮЙЦӨТГӨГЧ

2020 оны 04 сарын 22

Бүтэц А/68

Уг зөвлөлийн дарга

**Нийслэлийн татварын газрын дэргэдэх
Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай.

Зөвлөлийн дарга: Д.Цогтжаргал - Татварын ерөнхий газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

- Б.Батсайхан - Эрсдэлийн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- С.Төгсжаргал - Татварын хяналт шалгалт, арга зүйн газрын үнэ шилжилтийн хэлтсийн дарга
- М.Болдбаатар - Нийслэлийн Татварын газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
- М.Мөнх-Алдар - Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн шинжээч
- Д.Мөнхтуул - Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын Хуулийн асуудал эрхэлсэн татварын улсын байцаагч
- Х.Нямбаяр - Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт Удирдах зөвлөлийн гишүүн
- Б.Уянга - Татварын мэргэшсэн зөвлөх нийгэмлэгийн гишүүн

Нарийн бичгийн дарга: Ж.Эрдэнэбүрэн - Нийслэлийн татварын газрын Хуулийн хэлтсийн магадлагч татварын улсын байцаагч

2. Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цаг тутамд 20,000 /хорин мянга/ төгрөгийн хөлс олгохыг Нийслэлийн татварын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Цогтнаран/-д зөвшөөрсүгэй.

0000011



**ТАТВАРЫН ӨРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 1/32

Улаанбаатар хот

**Нийслэлийн татварын газрын дэргэдэх
Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай.

Зөвлөлийн дарга: Д.Цогтжаргал - Татварын ерөнхий газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

- Гишүүд:
- Б.Батсайхан - Эрсдэлийн удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
 - Ц.Одончимэг - Татварын хяналт шалгалт арга зүйн газрын Үнэ шилжилтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
 - М.Болдбаатар - Нийслэлийн татварын газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
 - М.Мөнх-Алдар - Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын захиргааны хэм хэмжээний актыг хяналт бүртгэлийн хэлтсийн шинжээч
 - Я.Ариунцэцэг - Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын Хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагч
 - Х.Нямбаяр - Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Удирдах зөвлөлийн гишүүн
 - Б.Уянга - Татварын мэргэшсэн зөвлөх нийгэмлэгийн гишүүн

Нарийн бичгийн дарга: Б.Бадамцэцэг - Нийслэлийн татварын газрын Хуулийн хэлтсийн магадлагч татварын улсын байцаагч

2. Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цаг тутамд 20,000 (хорин мянга) төгрөгийн хөлс олгохыг Нийслэлийн татварын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Цогтнаран) д зөвшөөрсүгэй.

3. Татвар төлөгчийн өргөдөл, гомдлын хууль, журамд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэж байхыг Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөл (Д.Цогтжаргал) д үүрэг болгосугай.

Ташаа 2020019



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Нийслэлийн татварын газрын дэргэдэх
Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.9, 77 дугаар зүйлийн 77.7.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 466 дугаар тогтоолоор батлагдсан "Маргаан таслах зөвлөлийн ажиллах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай

Зөвлөлийн дарга:

Б.Буйаннэмэх Татвар төлөгчид үйлчлэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Б.Батсайхан Эрсдэлийн удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Одончимэг Татварын хяналт, шалгалт, арга зүйн газрын Үнэ шилжилтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

М.Болдбаатар Нийслэлийн татварын газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

М.Мөнх-Алдар Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн шинжээч

Я.Ариунцэцэг Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын Хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагч

Х.Нямбаяр Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн Удирдах зөвлөлийн гишүүн

Г.Хишигзул Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн гишүүн

Нарийн бичгийн дарга:

М.Гангамаа Нийслэлийн татварын газрын Хуулийн хэлтсийн магадлагч татварын улсын байцаагч



0000013

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/80

Улаанбаатар хот

Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.9, 77 дугаар зүйлийн 77.1, 77.7.3 дахь заалтад заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Б.Буяннэмэх Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга

Гишүүд:

Б.Батсайхан Эрсдэлийн удирдлагын газрын дарга

Ц.Одончимэг Татварын хяналт, шалгалт, арга зүйн газрын Үнэ шилжилтийн хэлтсийн дарга

Б.Норжинлхам Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн орлогын мэргэжилтэн

М.Мөнх-Алдар Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн шинжээч

Я.Ариунцэцэг Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын татварын улсын байцаагч

Х.Нямбаяр Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Удирдах зөвлөлийн гишүүн

Г.Хишигзүл Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн гишүүн


Нарийн бичгийн дарга:

Ж.Туяасайхан Нийслэлийн Татварын газрын Хуулийн хэлтсийн татварын улсын байцаагч

2. Нийслэлийн Татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цаг тутамд 20,000 /хорин мянга/ төгрөгийн хөлс олгохыг Нийслэлийн Татварын газрын дарга /Б.Цогтнаран/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Нийслэлийн Татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Татварын ерөнхий газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/82 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.ЗАЯАБАЛ

151611415



0000014

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 621

Улаанбаатар хот

Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.6.4, 42 дугаар зүйлийн 42.3, 42.4 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Татварын газар, хэлтсийн дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтад дурьдсанаар шинэчлэн баталсугай.

2. Аймгийн Татварын газар, хэлтсийн дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлийн гишүүдэд хуралдсан цаг тутамд 5000 (таван мянга) төгрөгийн хөлс олгохыг Аймгийн Татварын хэлтсийн дарга нарт зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2010 оны 05 сарын 24-ны өдрийн 283 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Т. БАТМАГНАЙ

81618

ТЭГ-ын даргын 2013 оны 08...
сарын 28-ны өдрийн 621-тоот
тушаалын хавсралт

1. Архангай аймаг

Зөвлөлийн дарга:

- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн
- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн
- МҮХАҮ-ийн танхимын Архангай аймаг дахь салбарын дарга
- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар хураалтын тасгийн аж ахуйн нэгж хариуцсан татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

2. Баянхонгор аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
- МҮХАҮ-ийн танхимын Баянхонгор аймаг дахь салбарын дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн татварын улсын байцаагч
- Эрсдэлийн удирдлага, мэдээллийн тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

3. Баян-Өлгий аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
- МҮХАҮ-ийн танхимын Баян-Өлгий аймаг дахь салбарын дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн татварын улсын байцаагч
- Эрсдэлийн удирдлага, мэдээллийн тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

4. Булган аймаг

Зөвлөлийн дарга:

- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Төрийн захиргаа, хууль эрх зүй, эрсдэлийн удирдлагын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- ММНБИ-ийн гишүүн

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

5. Говь-Сүмбэр аймаг

Зөвлөлийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүй, эрсдэлийн удирдлагын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч
- Татвар хураалтын тасгийн татварын улсын байцаагч
- Аймгийн Аудитын газрын аудитор
- ММНБИ-ийн Говьсүмбэр аймаг дах салбарын нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга:

- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн татварын улсын байцаагч

6. Говь-Алтай аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
- МҮХАҮ-ийн танхимын Говь-Алтай аймаг дахь салбарын дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар хураалтын тасгийн татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

7. Дархан-Уул аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
- МҮХАҮ-ийн танхимын Дархан-Уул аймаг дахь салбарын дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Эрсдэлийн удирдлага, мэдээллийн тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

8. Дорноговь аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн
- Ажил олгогч эздийн холбооны дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар хураалтын тасгийн татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

9. Дорнод аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хяналт шалгалтын албаны дарга
- МҮХАҮ-ийн танхимын Дорнод аймаг дахь салбарын дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар хураалтын тасгийн татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

10. Дундговь аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
- МҮХАҮ-ийн танхимын Дундговь аймаг дахь салбарын дарга
- Эрсдэлийн удирдлага, мэдээллийн тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар хураалтын тасгийн татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

11. Завхан аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Аудитын газрын ахлах аудитор
- МҮХАҮ-ийн танхимын Завхан аймаг дахь салбарын дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн татварын улсын байцаагч /Татварын зөвлөх/

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

12. Орхон аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн
- МҮХАҮ-ийн танхимын Орхон аймаг дахь салбарын дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Эрсдэлийн удирдлага, мэдээллийн тасгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ шинжилгээний татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

13. Өвөрхангай аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн
- МҮХАҮ-ийн танхимын Өвөрхангай аймаг дахь салбарын дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар хураалтын тасгийн татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

14. Өмнөговь аймаг

Зөвлөлийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн хэлтсийн дарга, татварын улсын ахлах байцаагч

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
- МҮХАҮ-ийн танхимын Өмнөговь аймаг дахь салбарын дарга
- Татвар хураалтын хэлтсийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх хэлтсийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Эрсдэлийн удирдлага, мэдээллийн хэлтсийн дарга, татварын улсын ахлах байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

15. Сүхбаатар аймаг

Зөвлөлийн дарга:

- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн
- МҮХАҮ-ийн танхимын Сүхбаатар аймаг дахь салбарын дарга
- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

16. Сэлэнгэ аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн
- МҮХАҮ-ийн танхимын Сэлэнгэ аймаг дахь салбарын дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар хураалтын тасгийн татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

17. Төв аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн
- МҮХАҮ-ийн танхимын Төв аймаг дахь салбарын дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар хураалтын тасгийн татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

18. Ховд аймаг

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн
- ММНБИ-ийн Ховд аймаг дах салбарын дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Эрсдэлийн удирдлага, мэдээллийн тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар хураалтын тасгийн татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн хуулийн зөвлөх

19. Хөвсгөл аймаг**Зөвлөлийн дарга:**

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
- Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн татварын улсын байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

20. Хэнтий аймаг**Зөвлөлийн дарга:**

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
- МҮХАҮ-ийн танхимын Хэнтий аймаг дахь салбарын дарга
- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Татвар хураалтын тасгийн татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

21. Увс аймаг**Зөвлөлийн дарга:**

- Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
- МҮХАҮ-ийн танхимын Увс аймаг дахь салбарын дарга
- ТИНЗ нийгэмлэгийн Увс аймаг дахь салбарын дарга
- Татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч
- Эрсдэлийн удирдлага, мэдээллийн тасгийн татварын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

- Татвар хураалтын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагч



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 14142/

Улаанбаатар хот

Г Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Г
шинэчлэн батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.6 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

11	Тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого			
12	Тусгай хувь хэмжээгээр төлбөл зохих албан татвар			
13	Нийт төлбөл зохих татвар			
14	Урьд оны илүү(+), дутуу(-) төлөлт	5,000.00	5,000.00	
15	Үүнээс: суутган тооцооллоор төйсөн			
16	Төлсөн татвар			
17	Эцсийн тооцоогоор гарсан илүү(+), дутуу(-) төлөлт	5,000.00	5,000.00	
18	Ногдуулсан торгууль			
19	Ногдуулсан алданги			
20	НИЙТ ТАТВАРЫН ТӨЛБӨР			

ТООЦООГ:

Үйлдсэн:
УТӨХГ-ын татварын хяналт шалгалтын хэлтсийн
Татварын улсын байцаагч:
/ Х.Наранчимэг /
/ Т.Баасан /
/ Б.Төгсжаргал /

Тэмдэг:

Танилцаж зөвшөөрсөн:
"Петро чайна дачин тамсаг" ХХК-ны
Захирал
..... /ЖИАН ВЭЙДУН/
Ерөнхий нягтлан бодогч

Тамга (тэмдэг)

0000112



МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

Татварын улсын байцаагчийн 210297791 тоот
Шийтгэлийн хуудасны хавсралт

**"ПЕТРО ЧАЙНА ДАЧИН ТАМСАГ" ХХК -ИЙН "АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАР" -Н НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТООЦОО**

2018 он 12 сар 26 өдөр

Д/Д	Үзүүлэлт	2014		Зөрүү (2-3)
		тайлангаар	шалгалтаар	
0	1	2	3	4
1	Нийт борлуулалтын дүн	22,475,225,783.80	22,475,225,783.80	
2	Чөлөөлөгдөх орлогын дүн			
3	Татвар ногдох борлуулалтын орлогын дүн	22,475,225,783.80	22,475,225,783.80	
4	Татвар ногдох орлогоос хасагдах баримтаар нотлогдох зардалын дүн	22,475,225,783.80	22,475,225,783.80	
5	Зохицуулагдсан татвар ногдох орлогын дүн			
6	Тайлангаарх алдагдалыг баталгаажуулсан дүн			
7	Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн			
8	Ногдуулсан татвар			
9	Хөнгөлөгдөх татварын дүн			
10	Нийтлэг хувь хэмжээгээр толбол зохих албан татвар			
11	Тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого			
12	Тусгай хувь хэмжээгээр төлбөл зохих албан татвар			
13	Нийт толбол зохих татвар			
14	Урьд оны нлүү(+), дутуу(-) төлөлт	5,000.00	5,000.00	
15	Үүнээс: суутган тооцооллоор төлсөн			
16	Төлсөн татвар			
17	Эцсийн тооцоогоор гарсан нлүү(+), дутуу(-) төлөлт	5,000.00	5,000.00	
18	Ногдуулсан торгууль			
19	Ногдуулсан алданги			
20	НИЙТ ТАТВАРЫН ТӨЛБӨР			

ТООЦООГ:

Үйлдсэн:

УТОХГ-ын татварын хяналт шалгалтын хэлтсийн
Татварын улсын байцаагч:

/ Х.Наранчимэг /

/ Т.Баасан /

/ Б.Төгсжаргал /

Танилцаж зөвшөөрсөн:

"Петро чайна дачин тамсаг" ХХК-ны
Захирал

..... /ЖИАН ВЭЙДҮН/

Ерөнхий нягтлан бодогч

Тэмдэг:

Тамга (тэмдэг)

0000113



МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

Татварын улсын байцаагчийн 210297791 тоот Шийтгэлийн хуудасны хавсралт

"ПЕТРО ЧАЙНА ДАЧИН ТАМСАГ" ХХК -ИЙН "АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР" -Н НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛГИЙН ТООЦОО

2018 он 12 сар 26 өдөр

Д/Д	Үзүүлэлт	2016		Зөрүү (2-3)
		тайлангаар	шалгалтаар	
0	1	2	3	4
1	Нийт борлуулалтын дүн	36,636,792,002.10	36,636,792,002.10	
2	Чолоологдох орлогын дүн			
3	Татвар ногдох борлуулалтын орлогын дүн	36,636,792,002.10	36,636,792,002.10	
4	Татвар ногдох орлогоос хасагдах баримтаар нотлогдох зардалын дүн	36,636,792,002.10	36,636,792,002.10	
5	Зохицуулагдсан татвар ногдох орлогын дүн			
6	Тайлангаарх алдагдалыг баталгаажуулсан дүн			
7	Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн			
8	Ногдуулсан татвар			
9	Хөнгөлөгдох татварын дүн			
10	Нийтлэг хувь хэмжээгээр толбөл зохих албан татвар			
11	Тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого		30,463,329.20	30,463,329.20
12	Тусгай хувь хэмжээгээр толбөл зохих албан татвар		6,092,665.80	6,092,665.80
13	Нийт толбөл зохих татвар		6,092,665.80	6,092,665.80
14	Урьд оны илүү(+), дутуу(-) төлөлт	5,000.00	5,000.00	
15	Үүнээс: суутган тооцооллоор төлсөн			
16	Төлсөн татвар			
17	Эцсийн тооцоогоор гарсан илүү(+), дутуу(-) төлөлт	5,000.00	6,092,665.80	6,092,665.80
18	Ногдуулсан торгууль			1,827,799.70
19	Ногдуулсан алданги			1,218,533.20
20	НИЙТ ТАТВАРЫН ТӨЛӨӨГ			9,138,998.70

ТООЦООГ:

Үйлдсэн:

УТӨХГ-ын татварын хяналт шалгалтын хэлтсийн

Татварын улсын байцаагч:

/ Х.Наранчимэг /

/ Г.Баасан /

/ Б.Төгсжаргал /

Танилцаж зөвшөөрсөн:

"Петро чайна дачин тамсаг" ХХК-ны

Захирал

..... /ЖИЛН ВЭЙДУН/

Ерөнхий нягтлан бодогч

Тэмдэг:

Тамга (тэмдэг)

0000114



МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

Татварын улсын байцаагчийн 210297791 тоот
Шийтгэлийн хуудасны хавсралт

**"ПЕТРО ЧАЙНА ДАЧИН ТАМСАГ" ХХК -ИЙН "АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАР" -Н НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТООЦОО**

2018 он 12 сар 26 өдөр

Д/Д	Үзүүлэлт	2015		Зөрүү (2-3)
		тайлангаар	шалгалтаар	
0	1	2	3	4
1	Нийт борлуулалтын дүн	30,571,724,029.50	30,571,724,029.50	
2	Чөлөөлөгдөх орлогын дүн			
3	Татвар ногдох борлуулалтын орлогын дүн	30,571,724,029.50	30,571,724,029.50	
4	Татвар ногдох орлогоос хасагдах баримтаар нотлогдох зардалын дүн	30,571,724,029.50	30,571,724,029.50	
5	Зохцуулагдсан татвар ногдох орлогын дүн			
6	Тайлангаарх алдагдалыг баталгаажуулсан дүн			
7	Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн			
8	Ногдуулсан татвар			
9	Хөнгөлөгдөх татварын дүн			
10	Нийтлэг хувь хэмжээгээр төлбөл зохих албан татвар			
11	Тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого		56,753,140.00	56,753,140.00
12	Тусгай хувь хэмжээгээр төлбөл зохих албан татвар		11,350,628.00	11,350,628.00
13	Нийт төлбөл зохих татвар		11,350,628.00	11,350,628.00
14	Урьд оны илүү(+), дутуу(-) төлөлт	5,000.00	5,000.00	
15	Үүнээс: суутган тооцооллоор төлсөн			
16	Төлсөн татвар			
17	Эцсийн тооцоогоор гарсан илүү(+), дутуу(-) төлөлт	5,000.00	11,355,628.00	11,350,628.00
18	Ногдуулсан торгууль			3,405,188.40
19	Ногдуулсан алданги			2,270,125.60
20	НИЙТ ТАТВАРЫН ТӨЛБӨР			17,025,942.00

ТООЦООГ:

Үйлдсэн:
УТӨХГ-ийн татварын хяналт шалгалтын хэлтсийн
Татварын улсын байцаагч:

/Х.Наранчимэг /
/Т.Баасан /
/В.Төгсжаргал /

Тэмдэг:

Танилцаж зөвшөөрсөн:
"Петро чайна дачин тамсаг" ХХК-ий
Захирал
..... /ЖИАН ВЭЙДУН/
Ерөнхий нягтлан бодогч

Тамга (тэмдэг)

0000113



МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

Татварын улсын байцаагчийн 210297791 тоот
Шийтгэлийн хуудасны хавсралт

**"ПЕТРО ЧАЙНА ДАЧИН ТАМСАГ" ХХК -ИЙН "АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАР" -Н НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТООЦОО**

2018 он 12 сар 26 өдөр

Д/Д	Үзүүлэлт	2017		Зөрүү (2-3)
		тайлангаар	шалгалтаар	
0	1	2	3	4
1	Нийт борлуулалтын дүн	39,653,736,707.60	39,653,736,707.60	
2	Чөлөөлөгдөх орлогын дүн			
3	Татвар ногдох борлуулалтын орлогын дүн	39,653,736,707.60	39,653,736,707.60	
4	Татвар ногдох орлогоос хасагдах баримтаар нотлогдох зардалын дүн	39,653,736,707.60	39,653,736,707.60	
5	Зохцуулагдсан татвар ногдох орлогын дүн			
6	Тайлангаарх алдагдалыг баталгаажуулсан дүн			
7	Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн			
8	Ногдуулсан татвар			
9	Хөнгөлөгдөх татварын дүн			
10	Нийтлэг хувь хэмжээгээр төлбөл зохих албан татвар			
11	Тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого		2,399,619.10	2,399,619.10
12	Тусгай хувь хэмжээгээр төлбөл зохих албан татвар		479,923.80	479,923.80
13	Нийт төлбөл зохих татвар		479,923.80	479,923.80
14	Урьд оны илүү(+), дутуу(-) толголт	5,000.00	5,000.00	
15	Үүнээс: суутган тооцооллоор төлсөн			
16	Төлсөн татвар			
17	Эцсийн тооцоогоор гарсан илүү(+), дутуу(-) төлөлт	5,000.00	484,923.80	479,923.80
18	Ногдуулсан торгууль			143,977.10
19	Ногдуулсан албангн			95,984.80
20	НИЙТ ТАТВАРЫН ТӨЛӨВӨР			719,885.70

ТООЦООГ:

Үйлдсэн:

УТӨХГ-ын татварын хяналт шалгалтын хэлтсийн

Татварын улсын байцаагч:

/Х.Наранчимэг /

/Т.Баасан /

/Б.Төгсжаргал /

Танилцаж зөвшөөрсөн:

"Петро чайна дачин тамсаг" ХХК-ны

Захирал

..... /ЖИЛАН ВЭЙДУН/

Ерөнхий нягтлан бодогч

Тэмдэг:

Тамга (тэмдэг)

0000116

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН ШИЙТГЭЛИЙН ХУУДАСНЫ
ХУВИЙГ ГАРДУУЛСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 210297791

Улаанбаатар
хот

ТЕГ-ын дэргэдэх УТОХГ-ын Хяналт шалгалтын хэлтсийн татварын улсын байцаагч Х.Наранчимэг, Т.Баасан, Б.Төгсжаргал бид Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Эрх бүхий албан тушаалтан шийтгэлийн хуудасны хувийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор биечлэн танилцуулах, эсхүл харилцаа холбооны хэрэгсэл ашиглан хүргүүлнэ.” гэж заасныг баримтлан 2018 оны 12 сарын 26-ны өдрийн 210297791 тоот шийтгэлийн хуудасны хувийг холбогдогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Захирал Жиан Вэйдунд тоотод 2018 оны 12 сарын-ны өдөр биечлэн /холбооны хэрэгсэл ашиглан хүргүүлсэн бол энэ тухай бичих/ гардуулав.

“Петрочайна дачин тамсаг” ХХК-д оногдуулсан шийтгэлийн 62,415,752,080.57 төгрөг, нөхөн татварын 208,052,506,935.24 төгрөг, алдангийн 41,610,501,387.05 төгрөг, нийт 312,078,760,402.86 төгрөгийн төлбөрөөс

1. Нэмэгдсэн өртгийн албан татвар 289,049,413,387.42 төгрөгийг ТЕГ-ын Төрийн сан банкин дахь 100 900 000 302 тоот дансанд,
2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 26,884,826.48 төгрөгийг ТЕГ-ын Төрийн сан банкин дахь 100 900 000 203 тоот дансанд
3. Хувь хүний орлогын албан татвар 8,440,109,300.31 төгрөгийг Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн Улаанбаатар хотын банкин дахь 2609034156 тоот дансанд
4. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 14,562,352,888.64 төгрөгийг Дорнод аймгийн татварын хэлтсийн Хаан банкны 5422057702 тоот дансанд
5. Торгууль, алдангийн 104,026,253,467.42 төгрөгийг Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн Улаанбаатар хотын банкин дахь 2609034165 тоот дансанд тус тус шийтгэлийн хуудас гардуулсан өдрөөс хойш 15 хүртэл хоногийн дотор төлж барагдуулахыг “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Захирал Жиан Вэйдунд бэлнээр сайн дураараа биелүүлэхийг даалгасугай. Шийтгэлийн хуудастай танилцаад гаргасан санал, хүсэлт:

ШИЙТГЭЛИЙН ХУУДАСНЫ ХУВИЙГ ГАРДУУЛСАН

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН /Х.НАРАНЧИМЭГ/
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН /Т.БААСАН/
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН /Б.ТӨГСЖАРГАЛ/
/гарын үсэг/ /нэр/

ГАРДАЖ АВСАН:
ХОЛБОГДОГЧ: /...../ ЖИАН ВЭЙДУН /
/гарын үсэг/ /нэр/

ХОЛБОГДОГЧИЙН ХУУЛЬ ЁСНЫ
ТӨЛӨӨЛӨГЧ, ӨМГӨӨЛӨГЧ: /...../

0000118



МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА



[Петро чайна дачин тамсаг ХХК]-ийн

Захирал ЖИАН ВЭЙДУН

Ерөнхий нягтлан бодогч Танаа

[Зөвлөмж хүргүүлэх тухай]

УТОХГ-тай харьцдаг, 2005 оны 11 сарын 14 өдрийн хуулийн этгээдийн бүртгэлийн 9019006066 тоот гэрчилгээ, 2075385 тоот регистрийн дугаартай "Петро чайна дачин тамсаг" ХХК-ийн 2013.01.01-2017.12.31 дуустал албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд «Татварын хяналт шалгалт хийх томилолт» «Татварын хяналт шалгалт хийх ерөнхий удирдамж», Төлөвлөгөөт (бүрэн) шалгалтыг 2018 оны 09 сарын 12 өдрөөс 2018 оны 12 сарын 26 өдрийг хүртэл хийж түйцэтгэв.

Танай байгууллагад татварын хяналт шалгалтыг хийх явцад:

1. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн хэрэгжилтийн тухайд:

- Татварын хяналт шалгалтанд ирүүлсэн баримт бичгийн эмх цэгц: Анхан шатны баримтын бүрдэлгүй, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хуульд заасны дагуу Монгол хэл рүү орчуулж анхан шатны баримт бичгээ хөтөлж байх
- НББ-ийн анхан шатны бүртгэл хөтлөлт: НББОУС, СТОУС, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны бүртгэл хөтлөлтийг хийж байх
- НББ-ийн журмлын бичилт, бүртгэл хөтлөлт: НББОУС, СТОУС, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу журналын бичилт, бүртгэл хөтлөлтийг хийж байх
- НББ-ийн олон улсын стандартын хэрэгжилт: НББОУС, СТОУС, МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн хууль, МУ-ын Татварын багц хуулийг хэрэгжүүлж ажиллах
- Санхүүгийн тайлан, татварын тайлан, тэдгээрийн уялдаа холбоо: НББОУС, СТОУС, МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн хууль, МУ-ын Татварын багц хуулийг хэрэгжүүлж ажиллах

2. Татварын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн тухайд:

Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд: «18.1.Татвар төлөгч дараахь үүрэг хүлээнэ: 18.1.1.татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж тогтоосон хугацаанд төлөх; 18.1.14. хууль тогтоомжид заасан бусад үүрэг» гэж заасныг болон бусад татварын хууль тогтоомжийн заалтыг зөрчсөн зөрчил /дэлгэрэнгүйг хавсралт Маягт-06(2) үзнэ үү/ илэрлээ.

Иймд бид энэхүү зөвлөмжийг танай байгууллагын цаашдын үйл ажиллагаанд тусалцаа үзүүлэх үүднээс та бүхэнд хүргүүлж байгаа бөгөөд нягтлан бодох бүртгэл, татварын хууль, тогтоомжийн талаар мэргэжлийн байгууллагуудаас зохион байгуулж байгаа сургалтанд хамрагдан санхүү, татварын чиглэлээр ажилтан, албан хаагчдынхаа мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Татварын хяналт шалгалт нь дан ганц төсвийн орлогыг бүрдүүлэхэд чиглэгддэггүй, харин татвар төлөгч таныг эрсдэлээс хамгаалах, татварын асуудлаар сургах, зөвлөх, нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэхэд чиглэгддэг гэдгийг ойлгож бидэнтэй хамтран ажилласан эрхэм татвар төлөгч танд талархаж буйгаа үүгээр илэрхийлье.

Танд шаардлагатай цахим хаягууд: Татварын бүртгэл, ногдуулалт, төлөлт, тайлагналт- www.mta.mn, гар утасны аппликэйшн:-mta.mn, нягтлан бодох бүртгэл, татварын чиглэлээр мэргэжлийн тусалцаа үзүүлэх-www.monicspa.mn, www.cfta.mn

0000119



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Ж.ГАНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Улаанбаатар хот, ЧД 4-р хороо,
Бага тойруу /15160/, С.Данзангийн гудамж 4А,
Утас: (976-11) 32-13-09, E-mail: info@mta.gov.mn

2020.04.29 № 01/1385
танай _____-ны № _____-т

“Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн
гомдлын тухай

*Утасгүй
Хуульч
2020/4/29*

“Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд Улсын төсвийн орлого хяналтын газрын Хяналт шалгалтын хэлтсийн Татварын улсын байцаагчид татварын хяналт шалгалт хийж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэн 2018 оны 12-р сарын 26-ны өдрийн 0297791 тоот шийтгэлийн хуудсаар хариуцлага ногдуулсан байна.

Танайхаас ирүүлсэн албан бичгийн хүрээнд асуудлыг судалж үзэхэд тус компаний 2007-2010 оны татвар ногдуулалт төлөлтийн байдалд хяналт шалгалт хийсэн татварын улсын байцаагчийн 2011 оны 11-р сарын 23-ны өдрийн 210098 тоот актыг Маргаан таслах зөвлөлийн 2012 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 04 тоот тогтоолоор хүчингүй болгон шийдвэрлэжээ.

Татварын Ерөнхий хуулийн /1992 он, 2008 он, 2019 он/ 2 дугаар зүйлийн 2.2-т “Монгол улсын олон улсын гэрээнд татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө” гэж заасан боловч “Петрочайна дачин тамсаг” ХХК-тай байгуулсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” нь Монгол Улсын Засгийн газар болон хуулийн этгээдийн хооронд байгуулсан иргэний эрх зүйн харилцаанд хамаарах гэрээ тул Монгол Улсын олон улсын гэрээ гэж үзэх үндэслэлгүй. Энэ талаарх тодорхойлолтыг Гадаад харилцааны яамнаас авсан байна.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон батлагдсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн адил үйлчилнэ”, Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, 25.1.7-д “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” гэж зааснаас үзэхэд хуулиар ногдуулсан татварыг хөнгөлөх чөлөөлөх асуудал нь Улсын Их хурлын онцгой бүрэн эрхийн асуудал байх бөгөөд Монгол Улсын Засгийн газартай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээгээр татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

0000120


Иймд "Бүтээгдэхүүн хуваах гэрээ" нь олон улсын гэрээ биш болох нь тодорхой байх нөхцөлд татварын харилцаа нь татварын хууль тогтоомжоор зохицуулагдах бөгөөд Бүтээгдэхүүн хуваах гэрээний татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбогдох заалт нь МУ-ын татварын хууль тогтоомжид зааснаас давж үйлчлэх эрх зүйн үндэслэлгүй байна.

Мөн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэсэн татварын улсын байцаагчийн 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 0297791 дугаартай шийтгэлийн хуудсыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг "Дараах тохиолдолд эрх бүхий албан тушаалтан прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна", 2 дахь хэсэг "Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн, эсхүл гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор шалгаж, дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана" 3 дахь хэсэг "Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэр гаргасан даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ" гэж заасны дагуу прокурорын хяналт дор шалган шийдвэрлэх ажиллагаа явагдсан байна.

Түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэсэн татварын улсын байцаагчийн шийтгэлийн хуудастай холбогдох гомдлыг Татварын ерөнхий хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 /Татварын ерөнхий хууль /2019/-ийн 81.1/-д "татварын алба болон татварын улсын байцаагчийн зөрчил шалган шийдвэрлэхээс бусад асуудлаар гаргасан шийдвэрийн талаар татвар төлөгч нь захиргааны журмаар дараахь харьяаллаар гомдол гаргах эрхтэй", мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг "оролцогч энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлнэ" гэж тус тус заасны дагуу Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалттай байна.

Иймд татварын улсын байцаагчийн 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 0297791 дугаартай шийтгэлийн хуудастай холбогдох татвар төлөгчийн гомдлыг татварын албаны удирдлага нь хянан шийдвэрлэх эрх зүйн үндэслэлгүй байх тул гомдлыг буцаан хүргүүлэв.

ДАРГА



Б.ЗАЯАБАЛ

0000121



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
ТАТВАРЫН
МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

"Петрожайна дачин тамсаг" ХХК-ийн
гомдлын тухай

Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлийн хуралдааныг дарга Б.Тэлмүүн даргалж, гишүүд З.Энхболд, Б.Болормаа, А.Энхболд, Р.Мягмаржав, Д.Мөнхтамир, Т.Алтанзаяа, нарийн бичгийн дарга Ш.Цогзолмаа нарын бүрэлдэхүүнтэй хийж,

Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын татварын улсын байцаагч Х.Наранчимэг, Т.Баасан, Б.Төгсжаргал нар "Петрожайна дачин тамсаг" ХХК-ийн 2013-2017 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, татварын улсын байцаагчийн 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 210297791 дүгээр шийтгэлийн хуудсаар 3,601,392,310,522.10 төгрөгийн зөрчилд ногдуулсан нийт 312,078,760,403.10 төгрөгийн төлбөрийг татвар төлөгч эс зөвшөөрч Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлд гаргасан гомдлыг магадлагч татварын улсын ахлах байцаагч Ш.Цогзолмаа, магадлагч татварын улсын байцаагч М.Алтангэрэл нар магадалгаа хийж, танилцуулснаар хянан хэлэлцэв.

Хуралдаанд: "Петрожайна дачин тамсаг" ХХК-ийн санхүүгийн тайлангийн хэлтсийн дарга Гоу Юн Фен, санхүүгийн хэлтсийн дарга Э.Болормаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн Дэлжрэх, орчуулагч Үүрийнтуяа, Уранчимэг, Татварын ерөнхий газрын дэргэдэх Том татвар төлөгчийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Б.Мөнхлут, татварын улсын байцаагч Б.Төгсжаргал, Ц.Тогосмаа нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Гомдол гаргагч "Петрожайна дачин тамсаг" ХХК-ийн дэд ерөнхийлөгч Хуанг Лижун маргаан таслах зөвлөлд гаргасан гомдолдоо: Монгол Улсын Татварын ерөнхий газрын Улсын төсвийн орлого, хяналтын газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 01/852 тоот "Мэдээлэл авах тухай" албан бичиг ирүүлсний дагуу манай компанийн 2013-2017 онуудын татварын ногдуулалт, төлөлтөнд хяналт шалгалт хийсэн билээ.

Дээрх татварын ногдуулалт, төлөлтөнд хийсэн шалгалтаар тус компанийг дараах үндэслэлээр татвар төлөөгүй гэж нэр бүхий улсын байцаагч нар 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Дугаар 210297791 тоот "Шийтгэвэр"-ийн хуудсаар нийт 312,078,760,403.10 төгрөгийн нөхөн татвар, алданги, торгууль оногдуулсан актыг үйлдэж 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр шуудангаар ирүүлсэн байна. Үүнд:

1.Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас 26,884,826.48 төгрөгийн орлогын албан татвар төлөөгүй;

2.Гадаад ажиллагсад олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос 8,440,109,300.31 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутган авч төлөөт төлөөгүй;

0000122

3. Гадаадын туслан гүйцэтгэгч компаниудаар Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний орлогыг шилжүүлэхдээ 289,049,413,387.42 төгрөгийн Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган авч төсөвт төлөөгүй.

4. Үл хөдлөх хөрөнгөд ноогдох албан татварт 14,562,352,888.64 төгрөгийн татвар тооцож төлөөгүй.

5. Дээр дурдсан дөрвөн төрлийн татварын торгууль, алдангид 104,026,253,467.42 төгрөгийн төлбөр оногдуулж, нийт 5 үндэслэлээр акт тогтоосон байна.

Тус нэр бүхий Татварын улсын байцаагчийн дугаар 210297791 тоот "Шийтгэвэр"-ийн актыг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд дараах үндэслэлүүдээр тайлбарлаж байна.

Нэг. Манай толгой компани нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1996 оны 8 тоот зөвлөмжийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн дугаар 253 тоот, 1996 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн дугаар 183 тоот тогтоол, 1996 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн Дугаар ЗГ/144 тоот батламжаар баталсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний "Гэрээлэгч" бөгөөд өнөөг хүртэл дээрх гэрээг чанд баримтлан "Тамсагийн төсөл"-ийг амжилттай хэрэгжүүлж байна. (Засгийн газрын батламжилсан тогтоолыг хавсаргав)

Дээрх Бүтээгдэхүүн хуваах гэрээний 10.4 зүйл (г) заалт болох "Гэрээлэгч" нь (түүний дотор хувь нийлүүлэгчид болон хувьцаа эзэмшигчид) энэ гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд 10.2-т заасан урамшуулал, энэхүү 10.4-т заасан орлон төлөх орлогын татвар, Засгийн газрын байгууллагуудаас жинхэнэ үзүүлсэн үйлчилгээний ердийн хөлсийг төлөх бөгөөд харин орлогын татвар болон бүх татвар төлөхөөс чөлөөлөгдөнө" гэж заасны дагуу Манай компани нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон бусад бүх төрлийн татвар төлөхөөс чөлөөлөгддөг, мөн үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухайд гэрээний 10.4 (г) хэсэгт хамаарахгүй байна. НӨАТ-тай холбоотойгоор тус гэрээний 10.4 зүйл (е) заалтад "Гэрээлэгчийн гадаадын оролцон гүйцэтгэгч нь тэдгээрийн газрын төстой холбогдсон үйл ажиллагаанд ногдуулах, орлон төлөх орлогын татвар, орлогын татвар буюу бусад татвараас чөлөөлөгдөнө" гэж заасны дагуу манай компани нь НӨАТ суутган төлөхөөс чөлөөлөгдөж байна. Гэрээний дээрх хоёр заалтыг үндэслэн манай компанийн гэрээлэгч буюу туслан гүйцэтгэгч нь нэр бүхий улсын байцаагчийн актад дурдсан НӨАТ, ҮХХАТ болон ААНӨАТ-аас чөлөөлөгдөж байгаа бөгөөд татварын суутгал буюу төлөлт үүсэхгүй болно.

Мөн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 10.4 зүйл (ж) заалтад зааснаар "Гэрээлэгчийн болон оролцон гүйцэтгэгчийн гадаадын ажиллагсад нь Монгол Улсын Засгийн газар, тухайлбал түүний аль нэг улс төрийн байгууллагаас ногдуулах орлогын бүх татвар, нийгмийн даатгалаас чөлөөлөгдөнө" гэж заасан байна. Энэхүү зүйл заалтаар манай компани нь Монгол Улсын нутаг дэвсгэрт 183 хоног хэтэрсэн эсэхээс үл хамааран гадаадын иргэний хувь хүний орлогын албан татварыг төлөхгүй байх үндэслэл юм.

Хоёр. Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 /...өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болгох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээдтэнэ.../. Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д /...Хараат болон охин компани нь толгой компанийхаа өрийг хариуцахгүй бөгөөд хууль болон тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол толгой компани нь хараат болон охин компанийнхаа өрийг хариуцахгүй.../ тус тус заасны дагуу компани нь өөрийн нэрээр бие даасан эрх, үүрэг эдэлж эрх зүйн харилцаанд оролцдог.

Гэтэл ТЭГ-ын энэ удаагийн шалгалт нь Монгол Улсад бүртгэлтэй "Петрочайна Дачин Тамсаг" ХХК /РД:2075385/-ийн 2013-2017 онуудын хоорондох хугацааны татварын ногдуулалт, төлөлтийн байдалд чиглэгдэж шалгасан боловч тавьсан актад дурдсан тоонууд бүгд АНУ-д бүртгэлтэй "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн хийсэн гэрээ эсвэл цалин хөлс, төлбөрүүдээс үүдэлтэй гэж үзэхээр байна. (Тус компанийн бүртгэлийн гэрчилгээг хавсралт 2-оос харна уу). Учир нь "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн 2013-2017 онуудын хоорондох

хугацааны татварын ногдуулалтад хамаарах санхүүгийн баримтуудыг үндэслэвэл нэр бүхий татварын улсын байцаагч нарын акт, түүний тэмдэглэлд дурдсан их хэмжээний орлого, зарлага үнэлгээний тоон дүн гарах боломжгүй юм. Үүнтэй холбоотойгоор манай салбар компаниудын бүтэц, хариуцлага, эрх зүйн чадвар, чадамжийн талаар өмнө нь УТЕГ-т 2011 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 11/1594 тоот явуулсан албан бичигт тодорхой тайлбарласан байдаг билээ. (Хавсралт 3)

Гурав. Татварын улсын байцаагч нар нь манай "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-иас тодорхой баримт, түүний орчуулгыг удаа дараа гаргуулж авахдаа шалгалт хийж байна гэх ерөнхий тайлбараас өөрөөр бүрэн, тодорхой тайлбар хэлэлгүй байсаар 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр шуудангаар татварын "Шийтгэвэр" оногдуулах тухай актыг бидэнд ирүүлсэн.

Татварын шийтгэвэр оногдуулах актын тэмдэглэлд дурдсан татвар оногдуулах тоо баримт нь манай санхүүгийн бодит тоо баримтаас илт зөрүүтэй, тоо баримтыг их хэмжээгээр үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн, гадаад валютаар тооцогдох төлбөр тооцооны дүнг төгрөгт шилжүүлэхдээ ямар ханшийг үндэслэн, хэрхэн хөрвүүлж тооцсон нь тодорхойгүй, энэ талаар гаргасан татварын актыг үйлдэхдээ нэр бүхий улсын байцаагч нар нь манай компанид актыг тайлбарлаж, танилцуулаагүй, татварын актад холбоотой тэмдэглэл, бусад баримт бичигтэй танилцаж тайлбар гаргах, тарын үсэг зурж баталгаажуулах боломж олгоогүй шууд гаргасан зэрэг нь Татварын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.Татварын алба, татварын улсын байцаагч нь бүрэн эрхээ үзрэгжүүлэхдээ татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, төдөнд итгэл үзүүлэн ажиллана, 17 дугаар зүйлийн 17.1.2.Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдгээх, татвараас чөлөөлөгдөх эрхтэй, 17.1.7.Татвар төлөгч нь татвар ногдуулалт, төлөлт, хяналт шалгалтын дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх эрхтэй, 23 дугаар зүйлийн 23.1.Татварын алба, татварын улсын байцаагч нь үйл ажиллагаандаа ...татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх... зарчим баримтална, 25 дугаар зүйлийн 25.1.Татварын алба, татварын улсын байцаагч энэ хуулийн 14 дүгээр зүйлийг дагаж мөрдөн татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмыг хангана, 30 дугаар зүйлийн 30.1.6.татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг үл хүндэтгэхийг хориглоно зэрэг заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

Дээр дурдсан үндэслэлүүдээр манай компанийн хувьд нэр бүхий татварын улсын байцаагчийн актад дурдсан шиг хууль тогтоомжийг зөрчсөн зүйл байхгүй бөгөөд "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-д ногдуулсан 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн дугаар 210297791 тоот "Шийтгэвэр" оногдуулсан актыг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

Иймд Татварын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6-д /татварын албанаас гаргасан акт, дүгнэлт, бусад баримт бичигтэй танилцах, үндэслэлгүй буюу хуульд нийцээгүй гэж үзвэл танилцсанаас хойш 30 хоногийн дотор томдлоо захиргааны болон шүүхийн журмаар гаргах/ гэж заасан эрхийн дагуу тус компанид тавьсан татварын байцаагчийн актыг Татварын маргаан таслах зөвлөлөөр хэлэлцүүлэн, шийдвэрлэж хүчингүй болгуулах хүсэлтийг гаргаж байна. Бидний энэхүү хүсэлтийг хүлээн авч нааштайгаар шийдвэрлэж өгч, бидний хууль ёсны эрх, ашиг сонирхол, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцөлөө хэрэгжүүлэх боломжоор хангаж өгөхийг Татварын ерөнхий газрын Татварын маргаан таслах зөвлөлийн гишүүдээс хүсч байна гэжээ.

Хариуцагч Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын татварын улсын байцаагч Б.Төгсжаргал маргаан таслах зөвлөлд гаргасан хариу тайлбартаа Татварын ерөнхий газрын дэргэдэх Том татвар төлөгчийн газар /хуучнаар Улсын төсвийн орлого, хяналтын газар/-ын Хяналт шалгалтын хэлтсийн даргын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 211809342 тоот томилолт олгогдсоны дагуу "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал татварын ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210297791 тоот татварын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсаар 3,601,392,310.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 312,078,760.4 мянган төгрөгийн төлбөр ногдуулсан,

Шийтгэлийн хуудсаар ногдуулсан төлбөрийг татвар төлөгч эс хүлээн зөвшөөрч ТЕГ-ын дэргэдэх Маргаан таслах зөвлөлд 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр гомдол гаргасан. Татвар төлөгчийн гаргасан гомдол тус бүрд дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. БНХАУ-ын "Дачин ойл Филд" ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай 2075385 тоот регистрийн дугаартай "Петро чайна дачин тамсаг" ХХК нь Монгол Улсын хуулийн дагуу 2005 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр байгуулагдсан бөгөөд газрын тос олборлох төслийн ажлыг 1993, 1995 онд Монгол Улсын Засгийн газартай байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа гэх боловч /гэрээний үүргийн хэрэгжүүлэгч этгээд биш/ Монгол Улсын Уул уурхайн яамнаас 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дугаар 234 тоот Тосон уул XIX, Тамсаг XXI талбайд газрын тос ашиглах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгогдсон байдаг.

Тус компанид татварын хяналт шалгалт хийх явцад Бүтээгдэхүүн хуваах гэрээ нь татварын болон бусад хууль тогтоомжтой нийцээгүй гэж үзэж байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон батлагдсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн адил үйлчилнэ".

2. Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1-д "Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ", 25.1.7-д "төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах" гэж зааснаар хуулиар ногдуулсан татварыг хөнгөлөх чөлөөлөх асуудал нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал байж бөгөөд Монгол Улсын Засгийн газартай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээгээр татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

3. Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Олон улсын гэрээ" гэж Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ" гэж зааснаас үзэхэд энэхүү "Бүтээгдэхүүн хуваах гэрээ" нь олон улсын гэрээнд хамаарахгүй байна.

4. Бүтээгдэхүүн хуваах гэрээ /цаашид БХГ гэх/ нь Олон улсын гэрээ биш тул дотоодын хууль тогтоомж буюу Татварын ерөнхий хуулиар зохицуулагдах харилцаа мөн болно. Энэ нь Татварын ерөнхий хууль /1992, 2008/-ийн 2 дугаар зүйлийн 2.2-т "Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө" гэж заасны дагуу олон улсын гэрээ биш тул Татварын хуулиар зохицуулагдана.

5. Татварын Ерөнхий хууль /1992 оны/-ийн 2 дугаар зүйлийн 3 д "татвар бий болгох, ногдуулах, өөрчлөх, чөлөөлөх, татвар төлөхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна" гэж заасан. Иймд "Петро чайна дачин тамсаг" ХХК-ийн татвар ногдуулалт төлөлт, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн харилцаа нь БХГ-ний заалтаар бус хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хууль тогтоомжоор зохицуулагдахаар байна.

6. БХГ нь тухай үед мөрдөгдөж байсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн хуулийн нэр томъёоны 4-т "Хөрөнгө оруулалтын гэрээ" гэж хуулийн этгээд байгуулахгүйгээр тодорхой төсөл хэрэгжүүлэх зорилгоор байгуулсан концесс, бүтээгдэхүүн хуваах тухай, маркетинг, менежмент, санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх хэлцлийг хэлэх" ээр заасан тул газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах зарчмаар Засгийн газартай байгуулсан гэрээг "хөрөнгө оруулалтын гэрээ" гэж үзэх үндэслэлтэй байх тул бүтээгдэхүүн хуваах зарчмаар гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу татвараа төлж, тайлагнахаар байна.

7. 1992 оны татварын үйлчлэлийн хүрээнд Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйл "Албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх"-ийн 7.2-т "Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах зарчмаар Монгол Улсын Засгийн газартай

байгуулсан гэрээний дагуу Монгол Улсын үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлогод түүнийг гадаад гуйвуулах үед энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2.шатлалын хувиар ногдох аж ахуйн нэгжийн орлогын албан татвар хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлогод 15 хувь, мөн зүйлийн 3 дахь хэсэгт эрхийн шимтгэлийн орлогод 10 хувиар гэж заасны дагуу ногдуулах татвараас тус тус чөлөөлнө",

8. БХГ нь Газрын тосны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т "Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчид Монгол Улсын хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр татвар ногдуулна" гэж тус тус заасан.

9. Уг БХГ нь олон улсын гэрээ байсан бол Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйл болон Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т тус тус заасны дагуу уг гэрээний 10 дугаар зүйлийн 10.4-т заасныг баримтлан татвараас чөлөөлөх нь үндэслэлтэй юм. Гэвч 1969 оны Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийн 1 дүгээр зүйлийн а-д "гэрээ" гэж "...улсуудын хооронд бичгээр байгуулсан..." гэрээг хэлдэг бөгөөд уг БХГ-г олон улсын гэрээ биш тухай Гадаад харилцааны яамнаас тодорхойлолт ирүүлсэн болно. Гадаад харилцааны яамнаас ирсэн 2017.09.29-ний 09/5625 тоот албан бичгийг хавсаргав!

Өмнө тус компанигай холбогдуулан гаргасан татварын улсын байцаагчийн актыг Маргаан таслах зөвлөлөөс удаа дараа хүчингүй болгож шийдвэрлэхдээ хууль тогтоомжийг үндэслэлийг нарийвчлан заагаагүй, БХГ нь хууль тогтоомжтой зөрчилдөж байгааг нотолсон шийдвэрүүдийг гаргаж байсан байна. Монгол Улсын аливаа татварын хууль тогтоомжид татвар төлөгчийн төлөх ёстой албан татварыг Засгийн газар хариуцаж төлөх тохиолдолд татварын улсын байцаагчийн шийдвэрийг хүчингүй болгох эрх Маргаан таслах зөвлөлд олгоогүй байна. Түүнчлэн Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах эрх бүхий этгээд нь Монгол Улсын Дээд шүүх тул Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөл нь "...одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөлт оруулсны дараа татвар ногдуулах асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна" гэх дүгнэлт гаргах эрх бүхий этгээд биш юм.

Хоёр. Хяналт шалгалтын явцад баримт материалын хүсэлт болон газрын даргын албан тогтоор удаа дараалан Монгол Улсад бүртгэлтэй "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн бүтэц зохион байгуулалт, тогтмол компаниудын зураглал, тэдгээрийн эрх үүрэг, бүтээгдэхүүн хуваах гэрээ болон түүний албан ёсны орчуулгыг нотлох баримтын хүрээнд шаардсан боловч хяналт шалгалтын хугацааны туршид гаргаж өгөөгүй билээ.

Монгол Улсын Засгийн газар нь 1993 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Тосон уул XIX талбайг "Медаллион Монгол Ойл" компани /Засгийн газрын 1993.07.23-ны 253 дугаар тогтоолоор/, 1995 оны 12 дугаар сарын 11-ний өдөр "Соко тамсаг Монголиа Инк" компани /Засгийн газрын 1996.08.09-ны 144 дүгээр тогтоол/-уудад тус тус бүтээгдэхүүн хуваахаар гэрээлсэн. Харин БХГ-ний "Гэрээлэгч"-ийн эрх, үүргийг БНХАУ-ын "Дачин Ойл фийлд" ХХК-ийн харилцан хамаарал бүхий компани болох АНУ-ын Делавер мужид бүртгэлтэй "Петрочайна дачин тамсаг" компани хэрэгжүүлдэг болох нь Маргаан таслах зөвлөлд гаргасан гомдлод тодорхойлсон байна.

Дээр дурдсанаар хэдийгээр БХГ-нд гэрээлэгчийн үүргийг АНУ-д бүртгэлтэй "Петрочайна дачин тамсаг" компани эзэмшдэг боловч, Монгол Улсын Уул уурхайн яамнаас 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 234 тоот Тосон уул XIX, Тамсаг ХХК талбайд газрын тос ашиглах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл Монгол Улсад бүртгэлтэй "Петрочайна дачин тамсаг" ХХК-д олгогдсон байдаг.

Тамсаг ХХК талбайд байгуулсан БХГ-ний 10.4 а-д "Гэрээлэгч болон түүнтэй адилтгах татвар төлөгчид хамаарах МУ-ын Засгийн газрын орлогын хувиар тооцсон татварыг төлөөлүүлэн (орлогын орлом төлөгдөх татвар) төлнө. Гэрээлэгч нь нийт орлого, зөвшөөрөгдсөн хөнгөлөлт болон орлом төлөгдөх татварын хэмжээг харуулсан жил бүрийн тайланг МУ-ын татварын холбогдох байгууллагуудад танилцуулна" гэсэн бэл Тосон уул XIX

БХГ-ний хувьд мөн заалтад "орлогын татварын жилийн эцсийн тооцоог дараа оны нэгдүгээр сард багтаан Монголын Татварын байгууллагатай хийж байна" гэж тус тус заажээ. Энд тайлбарт дурдсаны дагуу Гэрээлэгч АНУ-ын гэрээлэгч тал нь АНУ-д бүртгэлтэй "Петрочайна дачин тамсаг" компани Монгол Улсын Татварын албанд нийт орлого, хөнгөлөлт, орлогын орлон төлөгдөх татварын хэмжээг харуулсан хоёр талбайн хувьд тус тусад нь хүргүүлэх үүрэгтэй. Гэвч өнөөдрийг хүртэл БХГ-ний "Гэрээлэгч"-д нь дээрх гэрээний үүргээ биелүүлээгүй буюу Монгол Улсын Татварын албанд газрын тосны нийт орлогоо тайлагнаж байгаагүй билээ. Тухайлбал Монгол улсад бүртгэлтэй Петрочайна дачин тамсаг ХХК нь 2013-2017 онуудад Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар Улаанбаатар дахь оффисын үйл ажиллагаатай холбоотой санхүүжилт, түүнтэй холбогдон гарсан зардлын мэдээллийг л тайлагнасан буюу үйл ажиллагааны санхүүжилтийн дүн орлого гэж тайлагнан, уг дүнтэй адил хэмжээний дүнгээр удирдлага болон борлуулалтын үйл ажиллагааны зардлыг хасаж тооцон тайлагнасан байна. Харин БХГ-ний гэрээлэгч болон АНУ-д бүртгэлтэй "Петрочайна дачин тамсаг" компани дээрх гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэхийн тулд 2 талбайд тус бүрд нь татварын тайлан гаргаж, Монгол Улсын татварын албанд тушаах үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Гурав. Бид хяналт-шалгалтын томилолтыг гардан авахаас эхлээс хяналт шалгалтын үйл ажиллагаа дуусах хүртэлх хугацаанд Татварын ерөнхий хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, ТЕГ-ын даргын баталсан "Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам"-д заасны хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн билээ. Хяналт шалгалтын хугацаанд татвар төлөгчийг дарамталсан, тайлбар гаргаж өгөх нөхцөл бололцоогоор хангаагүй, ТУБ нарын зүгээс ямар нэгэн ёсзүйн зөрчил гаргаагүй болно.

Харин хяналт шалгалтын хугацаанд шаардлагатай анхан шатны болон нотлох баримтыг нотлох баримтын шаардлагын хэмжээнд хугацаанд нь гаргаж өгөхгүй, хариуцагч талаас ямар албан тушаалтай хэн гэдэг хүн шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх нь тодорхойгүй, удирдлагын зүгээс хэн гэдэг хүнд хяналт шалгалтын үйл явцтай холбоотой мэдээллийг танилцуулах нь тодорхойгүй байсан нь хяналт шалгалтын ажил сунжирхад нөлөөлсөн болно. Уг ойлгомжгүй асуудлыг хэрхэн шийдвэрлэх, хяналт шалгалтын үйл явцтай холбоотойгоор ТУБ бид өөрсдийн хариуцсан нэгжийн даргын хамт "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн холбогдох хүмүүстэй тухай бүр, удаа дараа ТЕГ-ын байранд уулзалт зохион байгуулж байсан билээ.

Хяналт шалгалтын ажил дуусч, татварын улсын байцаагчийн шийтгэлийн хуудас үйлдэхтэй холбоотойгоор тус компанийн удирдлагууд /шийтгэлийн хуудастай танилцах/-тай холбогдох гэсэн боловч "БНХАУ руу түр хугацаанд буцсан байгаа" шалтгаанаар гардуулж чадаагүй, түүнтэй холбогдох баримтыг ирүүлээгүй тул хуульд заасны дагуу баталгаат шуудангаар хүргүүлсэн болно. Энэ удаагийн хяналт шалгалт нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмаар прокурорын хяналтад хийгдсэн бөгөөд эцсийн шийдвэр болгох шийтгэлийн хуудсыг прокуророс хянаад хууль тогтоомжид нийцсэн гэж үзсэн болно. Энэ нь хуулиар олгогдсон эрхийн хүрээнд хяналт тавих чиг үүргийн дагуу хийгдсэн прокурорын үйл ажиллагаа юм.

Хэрэв хяналт шалгалтын явцад процессын болон хууль хэрэглээний зөрчил гаргаж татвар төлөгч буюу хуулийн этгээдийн эрхийг зөрчсөн тохиолдолд шийтгэлийн хуудсыг хүчингүй болгох эрх нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөвхөн прокурорт болон Захиргааны хэргийн шүүхэд олгогдсон бөгөөд хууль тогтоомжид нийцсэн учир өнөөдөр энэхүү шийтгэлийн хуудас нь хүчинтэй хэвээр байгаа болно гэжээ.

ҮНДЭСЛЭХ НЬ:

Татварын улсын байцаагчид "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн 2013-2017 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, татварын улсын байцаагчийн 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210297791 дүгээр шийтгэлийн хуудсаар нийт 3,601,392,310,522.10 төгрөгийн зөрчилд 208,052,506,387.20 төгрөгийн нөхөн татвар,

62,415,752,080.60 төгрөгийн торгууль, 41,610,501,387.20 төгрөгийн алданги, нийт 312,078,760,403.10 төгрөгийн төлбөр ногдуулжээ.

Гомдол гаргагч нь нэр бүхий татварын улсын байцаагчийн 210297791 тоот "Шийтгэвэр"-ийн актыг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд ... манай толгой компани нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1996 оны 8 тоот зөвлөмжийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн дугаар 253 тоот, 1996 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн дугаар 183 тоот тогтоол, 1996 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн Дугаар ЗГ/144 тоот батламжаар баталсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний "Гэрээлэгч" бөгөөд өнөөг хүртэл дээрх гэрээг чанд баримтлан "Тамсагийн төсөл"-ийг амжилттай хэрэгжүүлж байна. ... гэрээний 10.4 (г)-д "Гэрээлэгч" нь (түүний дотор хувь нийлүүлэгчид болон хувьцаа эзэмшигчид) энэ гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд 10.2-т заасан урамшуулал, энэхүү 10.4-т заасан орлон төлөх орлогын татвар, Засгийн газрын байгууллагуудаас жинхэнэ үзүүлсэн үйлчилгээний ердийн хөлсийг төлөх бөгөөд харин орлогын татвар болон бүх татвар төлөхөөс чөлөөлөгдөнө" гэж заасны дагуу ... аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон бусад бүх төрлийн татвар төлөхөөс чөлөөлөгддөг, мөн үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухайд гэрээний 10.4 (г) хэсэгт хамаарахаар байна, ... гэрээний 10.4 (е), (ж) заалтын дагуу манай компани нь нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөхөөс чөлөөлөгдөж байна, ... Монгол Улсын нутаг дэвсгэрт 183 хоног хэтэрсэн эсэхээс үл хамааран гадаадын иргэний хувь хүний орлогын албан татварыг төлөхгүй байх үндэслэл юм ..." гэж, татварын улсын байцаагчдын зүгээс "Бүтээгдэхүүн хуваах гэрээ" нь тухайлсан татварын ярилцааг нарийвчлан зохицуулсан татварын хуулийг дааж үйлчлэх бөгүй гэж тайлбар, үндэслэлүүдийг гаргаж маргасан байна.

Маргаан бүхий нөхцөл байдлыг судлан үзвэл, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Монгол газрын тос (МГТ) компани болон АНУ-ын "Медаллион монгол ойл" компанийн хооронд 1993 оны 04 дүгээр сарын 26-ний өдөр Тосон-Уул XIX талбай, мөн Монгол газрын тос болон АНУ-ын "Территориол ресурсис" компани, Австрали Улсын "Комманд петролеум" компани, олон улсын газрын тосны концерциумын хооронд Магад XX, Тамсаг XXI талбайд 1995 оны 12 дугаар сарын 11-ний өдөр "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-г байгуулж, уг гэрээг Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 253 дугаар, 1996 оны 08 дугаар сарын 7 ны өдрийн 183 дугаар тогтоолоор тус тус баталжээ.

АНУ-д бүртгэлтэй "Соко Тамсаг Монгол" компани нь 2005 оноос өмнө Монгол Улсад газрын тостой холбогдсон үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байсан байна. БНХАУ-ын "Дачин Ойлфийлд лимитед" компани нь дээрх "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний эрх үүргийг АНУ-д бүртгэлтэй "Соко Тамсаг Монгол" компаниас 2005 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр шилжүүлэн авч, холбогдох бичиг баримтад уг компанийн нэрийг өөрчлөн АНУ-д бүртгэлтэй "Петрочайна Дачин Тамсаг" компани нэрээр шинэчлэн бүртгүүлсэн байна. БНХАУ-ын "Дачин Ойлфийлд лимитед" компани нь 2005 онд Монгол Улсад "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд газрын тосны хайгуул хийх, олборлох, бодвсруулах, тээвэрлэх ... үйл ажиллагааг хариуцан явуулдаг байна.

Татварын улсын байцаагчдын шийтгэлийн хуудсаар оногдуулсан зөрчлийг хянан магадлах явцад дараах нөхцөл байдал тогтоогдож байх тул түдгэлзүүлж, дээд шатны татварын албанд буцааж шийдвэрлэх нь зүйтэй гэж зөвлөлийн бүрэлдэхүүн дүгнэлээ.

Шийтгэлийн хуудсаар оногдуулсан 1 дэх зөрчлийн тухайд, Татварын улсын байцаагчид 2015-2017 онд нийт 89,616,088.28 төгрөгийн оршин суугч бус этгээдээр гүйцэтгүүлсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг гадагш шилжүүлэхдээ аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган тооцож тайлагнаагүй зөрчилд 17,923,217.60 төгрөгийн нөхөн татвар, 5,376,963.20 төгрөгийн торгууль, 3,584,643.60 төгрөгийн алданги, нийт 26,884,826.40 төгрөгийн төлбөр ногдуулжээ.

"Петрочайна Дачин Тамсаг" ХХК нь 2015-2017 онд АНУ-ын "Thompson & Knight LLP" компанид хуулийн үйлчилгээний төлбөр, хураамжид нийт 80,616,088.28 төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн боловч албан татвар ногдуулан суутгаж, тайлагнаагүй зөрчилд

хариуцлага оногдуулсныг буруутгах үндэслэлгүй боловч "Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам /2017 оны/-ын 6.4.2-т заасан татварын хяналт шалгалтын явцад оршин суугч бус этгээдийн үзүүлсэн ажил, үйлчилгээний гэрээ, хэлцэлтэй холбоотой баримтыг татвар төлөгчөөс шаардах, гаргуулах үүргээ татварын улсын байцаагчид хэрэгжүүлээгүй байна.

Иймд, татвар төлөгчийн "... актын тэмдэглэлд дурдсан татвар оногдуулах тоо баримт нь манай санхүүгийн бодит тоо баримтаас илт зөрүүтэй, тоо баримтыг их хэмжээгээр үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн, гадаад валютаар тооцогдох төлбөр тооцооны дүнг төгрөгт шилжүүлэхдээ ямар ханшийг үндэслэн, хэрхэн хөрвүүлж тооцсон нь тодорхойгүй, улсын байцаагч нар нь манай компанид актыг тайлбарлаж, танилцуулаагүй, татварын акттай холбоотой тэмдэглэл, бусад баримт бичигтэй танилцаж тайлбар гаргах, гарын үсэг зурж баталгаажуулах боломж олгоогүй ..." гэх гомдол үндэслэлтэй гэж үзэж, түдгэлзүүлж, дахин шалгуулахаар дээд шатны татварын албанд буцааж шийдвэрлэх нь зүйтэй гэж зөвлөлийн бүрэлдэхүүн үзлээ.

Шийтгэлийн хуудсаар оногдуулсан 2 дахь зөрчлийн тухайд, Татварын улсын байцаагчид 2013-2017 онд нийт 1,618,039,209,848.94 төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгөнд үл хөдлөх хөрөнгийн албан татвар ногдуулан төлөөгүй зөрчилд 9,708,235,259.20 төгрөгийн нөхөн татвар, 2,912,470,577.80 төгрөгийн торгууль, 1,941,647,051.90 төгрөгийн алданги, нийт 14,562,352,888.90 төгрөгийн төлбөр ногдуулжээ.

Татварын улсын байцаагчид "Петрочайна Дачин Тамсаг" ХХК нь 2013 онд 208,878,136,423.70 нэгдсэн байгууламж, шахалтын станцад, 2014 онд 253,004,946,249.10 төгрөгийн 2 ширхэг нэгдсэн байгууламж, шахалтын станцад, 2015-2017 онд 385,385,375,725.38 төгрөгийн 2 ширхэг нэгдсэн байгууламж, шахалтын станцад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулж төлөөгүй гэж үзжээ.

Татвар төлөгч "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн хувьд дээрх үл хөдлөх эд хөрөнгүүдэд Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар тайлагнасан эсэх асуулдаар маргаагүй. Тагцруу санхүүгийн бодит тоо баримтаас илт зөрүүтэй, тоо баримтыг их хэмжээгээр үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн, тодорхойгүй, танилцуулаагүй үндэслэлээр маргаж байх тул хяналт шалгалтын явцад татварын улсын байцаагчид "Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам /2017 оны/-ын 6.4.2, 6.4.3-т заасны дагуу дээрх үл хөдлөх хөрөнгүүдийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн, гэрчилгээ авсан эсэх, санхүүгийн тайланд бүртгэсэн эсэх, мөн хөрөнгийн үнэлгээг тооцох эх сурвалжийг тодруулах шаардлагатай байжээ.

Өөрөөр хэлбэл, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль /2000 оны/-ийн 3 дугаар зүйлийн 3.1-д "... Иргэний хуулийн 84.3-т заасны дагуу тодорхойлогдсон бүх төрлийн үл хөдлөх эд хөрөнгөнд албан татвар ногдуулна", 5 дугаар зүйлийн 5.1-д "Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг уул хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр, ... бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, ... даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр түс түс тодорхойлно", 6 дугаар зүйлийн 6.1-д "Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал ... 0.6-1.0 хувийар тооцож ногдуулна", 8 дугаар зүйлийн 8.1-д "Татвар төлөгч нь үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны байдлаар байгаа үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээгээр тооцно" гэж зааснаас үзвэл тухайн 2 ширхэг нэгдсэн байгууламж, шахалтын станцад үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ /улсын бүртгэлд бүртгэсэн эсэх/ гарсан эсэх, бүртгэгдсэн бол тухайн улсын бүртгэлд бүртгэгдсэн үнэлгээг харгалзахгүйгээр шууд данс бүртгэлд бүртгэгдсэн үнэлгээгээр зөрчилд тооцсон нь дээрх хуулийн зарчим /даргаалал/-д нийцэхгүй байна.

Шийтгэлийн хуудсаар оногдуулсан 3 дахь зөрчлийн тухайд, Татварын улсын байцаагчид "Петрочайна Дачин Тамсаг" ХХК нь 2013-2017 онд Britannia corporate management ltd, DQE International, Shandong Nine-Ring Petroleum Machinery Co.,Ltd, Great

Wall Drilling Company LTD, Daqniq oilfield limited company, Petrochina Daqing Petroleum Project Bidding Agent LLC, Panjin Liaone Oilfield Industrial co., LTD, Daqniq oilfield road&bridge engineering компаниудад нийт 1,926,996,089,249.49 төгрөгийн төлбөрийг шилжүүлэхдээ нэмэгдсэн өртгийн албан татвар суутган тооцож тайлагнаагүй зөрчилд 192,699,608,924.00 төгрөгийн нөхөн татвар, 57,809,822,677.50 төгрөгийн торгууль, 38,539,921,785.00 төгрөгийн алданги, нийт 289,049,413,386.50 төгрөгийн төлбөр ногдуулжээ.

Татварын улсын байцаагчдыг дээрх үндэслэлээр "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-д шийтгэлийн хуудсаар хариуцлага оногдуулсныг буруутгах үндэслэлгүй боловч хяналт шалгалтын явцад зайлшгүй шалгаж, тодруулах, нөхцөл байдлыг тогтоох ажиллагааг явуулаагүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Тухайлбал, татварын улсын байцаагчид "Петрочайна Дачин Тамсаг" ХХК нь дээр нэр дурдсан аж ахуйн нэгжүүдэд төлбөрийг шилжүүлэхдээ нэмэгдсэн өртгийн албан татвар суутган тооцож тайлагнаагүй зөрчил гэж үзсэн боловч нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах ямар харилцаа үүссэн болохыг баримтаар тогтоогоогүй.

Өөрөөр хэлбэл, шилжүүлж буй төлбөр нь тухайн компаниудын хувьд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан бараа эсхүл ажил, үйлчилгээний алин болохыг татварын хяналт шалгалтын явцад татвар төлөгчөөс гаргуулж шалгаагүй, тодруулаагүй. Энэ талаар татвар төлөгчийн "... санхүүгийн бодит тоо баримтаас илтэйрүүтэй, тоо баримтыг их хэмжээгээр үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн, гадаад валютгаар тооцогдох төлбөр тооцооны дүнг төгрөгт шилжүүлэхдээ ямар ханшийг үндэслэн, хэрхэн хөрвүүлж тооцсон нь тодорхойгүй ..." гомдол үндэслэлтэй бөгөөд магадалгааны явцад ирүүлсэн татварын улсын байцаагчдын жагсаалтаар ирүүлсэн мэдээллээр дээрх компаниудаар газрын гадаргуу дахь өрөмдлөгийн инженерчлэлийн, перфорацийн ажлын төлбөр, геологийн судалгаа, шавардлагын судалгаа шинжилгээ, хавхлаг, туузан халаагч, багаж хэрэгсэл, аппаратын зэрэг төлбөрүүд, цооногийн картаж, бүх төрлийн засвар үйлчилгээний, эрүүл мэндийн үзлэг, гадаад сургалтын төлбөр, шингэн хагалгааны инженерчлэлийн ажил тус тус гүйцэтгүүлсэн гэх нөхцөл байдлыг татвар төлөгчийн нотлох баримт /гэрээ/-аар тулган шалгаж, нягталж, тодруулах шаардлагатай гэж үзлээ.

Шийтгэлийн хуудсаар оногдуулсан 4 дэх зөрчлийн тухайд, Татварын улсын байцаагчид 2013-2017 онд нийт 56,267,395,335.39 төгрөгийн Монгол Улсын нутаг дэвсгэрт 183 хоногоос дээш хугацаагаар ажилласан гадаад ажиллагсдад олгосон хөдөлмөр эрхлэлтийн орлогод хувь хүний орлогын албан татвар суутган тооцож төсөвт төлөөгүй зөрчилд 5,626,739,533.50 төгрөгийн нөхөн татвар, 1,688,021,860.10 төгрөгийн торгууль, 1,125,347,906.70 төгрөгийн алданги, нийт 8,440,109,300.30 төгрөгийн төлбөр ногдуулжээ.

Татварын улсын байцаагчид Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /2006 оны/-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Дараах хувь хүнийг Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч гэж үзнэ: 6.1.2.тухайн татварын жилд 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад амьдарсан", 8 дугаар зүйлийн 8.1-д "Албан татвар төлөгчийн татварын жилд олсон дараах орлогод албан татвар ногдуулна: 8.1.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнаг, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 26 дугаар зүйлийн 26.3-т "Суутгагч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 26.1.6-д зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ" гэж заасныг зөрчсөн гэж үзэж, хариуцлага оногдуулж болох ч Татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг харгалзан үзэх ёстой.

Татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 15 дугаар зүйлийн 1-д "Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ажил үйлчилгээ эрхлээгүйгээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчийн ажил хийж авсан цалин хөлс болон

түүнтэй адилтгах орлогод 16, 18, 19, 20 ба 21 дүгээр зүйлд заасанчлан зөвхөн Хэлэлцэн тохирогч Улс татвар ногдуулна. Хэрэв ажил үйлчилгээг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж байгаа бол тэрхүү ажил үйлчилгээнээс олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулна", 2-т "Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад дор дурдсан нөхцөлд татвар оногдуулна", а) орлого авагч нь тухайн жилд нийт 183 өдрөөс илүүгүй хугацаагаар Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байсан бол; ..." гэж заасан.

Өөрөөр хэлбэл, БНХАУ-ын байнга оршин суугч ажилчдын цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогод зөвхөн БНХАУ татвар ногдуулна. Хэрэв ажил үйлчилгээг Монгол Улсад гүйцэтгэж байгаа бол тэрхүү ажил үйлчилгээнээс олсон орлогод Монгол Улс татвар ногдуулах, мөн хэлэлцээрийн 2-т зааснаар 1 дэх заалтыг үл харгалзан орлого авагч БНХАУ-ын ажилчид нь Монгол Улсад тухайн жилд нийт 183 өдрөөс илүүгүй хугацаагаар Монгол Улсад байсан бол БНХАУ татвар ногдуулахаар байна.










Дээрхээс үзвэл гомдол гаргагч "Петрочайна Дачин Тамсаг" ХХК нь 2013-2017 онд Хятад ажилчдын болон гадаадын /Extra/ ажилчид нь Монгол Улсад тухайн жилд нийт 183 өдрөөс илүүгүй, эсхүл түүнээс дээш хугацаагаар ажилласан эсэх талаар нотлох баримт байхгүй, холбогдох эрх бүхий байгууллагаас тодруулахгүйгээр тухайн жилд нийт 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад амьдарсан гэж үзэж хариуцлага оногдуулах нь хэлэлцээрийн дээрх зохихцуулалттай зөрчилдөж болзошгүй байна.

Нэгтгэн дүгнэвэл, дээр дурдсан зөрчлүүдэд холбогдох шаардлагатай баримт материалыг татвар төлөгч болон холбогдох эрх бүхий байгууллагаас гаргуулж нөхцөл байдлыг шалган тодруулах ажиллагаа нь маргаан таслах зөвлөлийн магадлан судлах боломжоос хэтэрсэн, магадлагаанд ирүүлсэн тайлбар, баримтын хүрээнд шийдвэрлэх боломжгүй байх тул татварын улсын байцаагчийн 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210297791 дүгээр шийтгэлийн хуудсыг түдгэлзүүлэх нь зүйтэй гэж зөвлөлийн бүрэлдэхүүн үзлээ.

Татварын ерөнхий хууль /2019 оны/-ийн 47 дугаар зүйлийн 47.10, "Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам"-ын 7.1.4-т заасныг тус тус удирдлага болгон **ТОГТООХ НЬ:**

1. Татварын ерөнхий 47 дугаар зүйлийн 47.11, 47.11.2 дахь заалтыг баримтлан татварын улсын байцаагчийн 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210297791 дүгээр шийтгэлийн хуудсыг түдгэлзүүлж, дахин шалгуулахаар дээд шатны татварын албанд буцаасугай.

ДАРГА
ГИШҮҮД:

		Б. ЦЭГИЙҮҮН
		З.ЭНХБОЛД
		Б.БОЛОРМАА
		З.ЭНХБОЛД
		Р.МЯГМАРЖАВ
		Д.МӨНХТАМИР
		Г.АЛТАНЗАЯА
		Ш.ЦЭГИЙҮҮН

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
ТАТВАРЫН МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 07 дугаар сарын 08

№ 02

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН нь:

Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлийн хуралдааныг маргаан таслах зөвлөлийн дарга Б.Тэлмүүн даргалж, гишүүн З.Энхболд, Б.Болормаа, А.Энхболд, Р.Мягмаржав, Д.Мөнхтамир, Г.Алтанзаяа, нарийн бичгийн дарга Ш.Цогзолмаа нарын бүрэлдэхүүнтэйгээр эхэлж, "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн санхүүгийн тайлангийн хэлтсийн дарга Гоу Юн Фен, санхүүгийн хэлтсийн дарга Э.Болормаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн Дэгжрэх, орчуулагч Үүрийнтуяа, Уранчимэг нарыг оролцуулан "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн татварын улсын байцаагчийн 210297791 дүгээр татварын улсын байцаагчийн шийтгэлийн хуудаст гаргасан гомдлыг хянан хэлэлцэх хуралдааныг Татварын ерөнхий газрын 706 тоот өрөөнд хийв.

Хуралдаан 10 цаг 50 минутад эхлэв.

СОНССОН нь:

Б.Тэлмүүн: "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн магадалгааг сонсьё.

Магадлагч Ш.Цогзолмаа, М.Алтангэрэл: "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн 2013-2017 оны татварын ногдуулалт төлөлтийн байдалд шалгалт хийж, 3.6 их наяд төгрөгийн 4 төрлийн зөрчилд 312.1 тэрбум төгрөгийн татвар ногдуулсан. Зөрчлийг нь задлаад үзвэл оршин суугч бус этгээдээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг гадагш шилжүүлэхдээ аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас суутгаагүй, 2-т оршин суугч бус этгээдээс Монгол улсын иргэн, хуулийн этгээдийн захиалгаар бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхдээ НӨАТ-ыг суутгаагүй, энэ нь бараа биш, ихэнхдээ ажил үйлчилгээ, 3-т 183-аас дээш хугацаагаар оршин суусан гадаад ажиллагаадад олгосон хөдөлмөрийн хөлсөнд ХХОАТ суутгаагүй, 4-т үл хөдлөх эд хөрөнгөд үл эдлэх эд хөрөнгийн хөрөнгийн албан татвар ногдуулж төлөөгүй гэсэн 4 төрлийн зөрчилтэй. Гомдолдоо "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн хувьд 2005 оноос өмнө АНУ-д бүртгэлтэй "Соко Тамсаг Монгол" компани газрын тостой холбогдсон үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаад дараа нь гэрээний эрх, үүргээ БНХАУ-ын "Дачин Ойлфийлд лимитед" компани шилжүүлж аваад дараа нэрээ өөрчлөн АНУ-д бүртгэлтэй "Петрочайна Дачин Тамсаг" компани нэрээр шинэчлэн бүртгүүлсэн байна. БНХАУ-ын "Дачин Ойлфийлд лимитед" компани нь 2005 онд Монгол Улсад "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийг үүсгэн байгуулсан.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний гол заалт 10.4.г-д "гэрээлэгч нь түүний дотор хувь нийлүүлэгч болон хувьцаа эзэмшигч, түншүүд болон бусад хувь эзэмшигчдэдээ заагаад өгчихсөн энэ гэрээг хүчин төгөлдөр байх хугацаанд 10.2-т заасан урамшуулал, 10.4-т заасан орлон төлөх орлогын татвар, Засгийн байгууллагуудаас жинхэнэ үзүүлсэн үйлчилгээний ердийн хөлсийг төлөх бөгөөд харин орлогын албан татвар болон бусад бүх татвар төлөхөөс чөлөөлөгдөнө. Яг энэ заалтаар аж ахуйн нэгжийн орлогын албан татвараасаа чөлөөлөгдөнө, үл хөдлөхийн татвараас чөлөөлөгдөнө гэж татвар төлөгч хэлдэг, энэ 10.4.г заалт гэрээлэгч нь /түүний дотор хувь нийлүүлэгчид болон хувьцаа эзэмшигчид, түншүүд, болон бусад хүү ооомшигчид/ энэ гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд 10.2-т заасан урамшуулал, энэхүү 10.4 заасан орлон төлөх орлогын татвар Засгийн газрын

0000132

байгууллагуудаас жинхэнэ үзүүлсэн үйлчилгээний ердийн хөлс төлөх бөгөөд харин орлогын татвар, болон бусад бүх татвар төлөхөөс чөлөөлөгдөнө. Энэхүү заалтаар нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөнө гэж маргадаг. Мөн 10.4-ж заалтаар гэрээлэгчийн болон орон гүйцэтгэгчийн гадаадын ажиллагсад нь Монгол Улсын Засгийн газар, тухайлбал, түүний аль нэг улсын төрийн байгууллагаас нь ногдуулах орлогын бүх татвар нийгмийн даатгалаас чөлөөлөгдөнө гээд, энэ заалтаар ХХОАТ-аас чөлөөлөгдөнө гэж үздэг.

Магадалгааны явцад гэрээ байгуулагдах үеийн хууль эрх зүйн орчныг судлан оруулж байна. Газрын тосны тухай хуулийн 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн хуулийн 9.2-т газрын тусгай холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчид Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хувь хэмжээгээр татвар ногдуулна, 9.3-т газрын тос олборлосны төлбөр, татвар төлөх хэлбэрийг гэрээлэгч болон газрын тосны хэрэг эрхлэх байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно гэж заасан. Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуулийн 9.4-т гэрээлэгчийн татварын хувь хэмжээг болон татварын орчныг тогтворжуулах асуудлыг Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан журмаар зохицуулна гэж заасан байна.

Татварын ерөнхий хууль /1992 оны/ -иар татварыг УИХ-аар хуулиар бий болгож, өөрчилж, хүчингүй болгон нэг л заалттай байна, мөн татвар хөнгөлөлт чөлөөлөх асуудлыг зөвхөн татварын хуулиар зохицуулна гээд заагаад өгчихсөн байна. Тогтвортой байдлын гэрээг байгуулж, хүчин төгөлдөр байх хугацаанд уг гэрээний тал, түүнийг байгуулснаас хойш батлагдсан хууль тогтоомж, заалтаас үл хамааран тогтвортой мөрдөнө гэсэн Татварын ерөнхий хуульд орсон гол гол өөрчлөлтүүд нэмэгдсэн. Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны тул тогтворжуулах гэрчилгээгээр татварын хувь, хэмжээг Засгийн газраас хөрөнгө оруулагчидтай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээгээр тогтворжуулна гэсэн нэмэлт өөрчлөлтийг 2013 онд Татварын ерөнхий хуульд оруулж өгсөн байгаа.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд /1993 оны/ гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид татварын хуульд зааснаас илүү таатай нөхцөл олгох асуудлыг энэ хууль түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаар шийдвэрлэнэ гэсэн заалттай. Энэ нь 18.2, 19, 20 гэсэн заалт байгаа. 1998 онд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар эдгээр заалт хүчингүй болсон байна.

Магадалгааны явцад шаардлагатай хэд хэдэн асуудлыг тодруулахаар баримт материал шаардахад магадалгааны явцад баримт материалыг шаардахад гаргаж өгөөгүй, учир нь тэр үед ковидын нөхцөл байдлын үе таарсан, бүх баримтууд байхгүй, нэлээд олон оны баримт ухахад хэцүү гэсэн тайлбар өгсөн. Оршин суугчийн сертификатыг шаардсан боловч авчирч өгөөгүй, жишээлбэл оршин суугч бус компанитай хийсэн ажил үйлчилгээний гэрээнүүдийг маргааны оршлогч талуудаас шаардсан боловч ирүүлээгүй учраас ямар ажил үйлчилгээ үзүүлсэн, юуны төлбөр шилжүүлээд байгаа, юунд зарцуулсан нь тодорхойгүй, мэдэгдэхгүй байна. Мөн үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувьд хаана байгаа үл хөдлөх хөрөнгө вэ гэж тодруулахаар 19, 21 дүгээр талбайд байгаа ажиллагчдын байр, оффисын барилга, нэгдсэн том байгууламж, шахуурга, эдгээр нь санхүүгийн тайланд байхгүй, мөн үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ шаардахад үл хөдлөхийн гэрчилгээ орооно байхгүй, Монгол Улсад 183 хоногоос дээш хугацаагаар оршин суусан гэдгийг нотлох ямар нэгэн бичиг баримт ирүүлсэнгүй, нөгөө талдаа бид байцаагчаас тодруулахад гаргаж өгөөгүй гэсэн тайлбар өгсөн. Татварын улсын байцаагчид "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн өөрсдийнх нь гаргаж өгсөн өртөг нөхөлтийн зардлаас эдгээр зардлыг авч зөрчил гэж үзсэн байна. 183 хоногийг тодруулсан уу гэхээр төслийн хугацаанд төсөл их удаан хугацаанд үргэлжилж байгаа учраас тэдгээрийг бид 183 хоногоос дээш гэж үзсэн, гэхдээ татвар төлөгчөөс шаардсан боловч ирүүлээгүй байна. Эдгээрийг тодруулбал, зарим нэг хуулийн заалтыг тодруулж харах хэрэгтэй байгаа юм.

Магадалгааны явцад тодруулсан зүйл нь Хууль зүй дотоод хэргийн яам болон Гадаад харилцааны яамнаас олон улсын гэрээ мөн үү гэдгийг лавлагаа авсан, олон улсын гэрээ биш гэсэн, өөрөөр хэлбэл хувийн эрх зүйн олон улсын гэрээ, тийм учраас дотоодын хууль тогтоомжийг гаргаж мөрдөх зохицуулалттай л харагдаад байгаа юм. Тэгээд түрүүн хэлсэн тодруулах шаардлагатай зүйлүүд байна, хянан шалгалтын явцад ч гэсэн тодруулах шаардлагатай байсан, мөн магадалгааны явцад тодруулах шаардлагатай уулзаж ярилцлага хийсэн, тодруулсан, шаардсан боловч "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн хувьд татварын алба болон санхүүгийн тайланд Улаанбаатар оффисынхоо зардлыг л тайлагнадаг, 19, 21 дүгээр талбайн зардлыг ерөөсөө тайлагнадаггүй, зөрчлөөр тооцсон зардлууд нь өртөг нөхөлтийн зардалд орсон байдаг юм байна. Гэхдээ зарим зүйлийг зайлшгүй тодруулах хэрэгтэй байжээ гэж үзэж байна.

Б.Тэлмүүн: Гишүүд асуух асуулт байна уу

Г.Алтанзаяа: Магадлагчийн оруулж байгаа эцсийн санал?

Магадлагч Ш.Цогзолмаа: Тодруулах асуудлууд байна.

Б.Тэлмүүн: Магадлагчийн санал нэмж тодруулъя гэж байгаа юм уу, актыг хэвээр нь батлуулах юм юу?

Магадлагч Ш.Цогзолмаа, М.Алтангэрэл: Актыг хэвээрээ гээд магадлагчийн саналаа явуулсан байгаа. Гэхдээ тодруулах зүйлүүд байна, мөрдөгдөж байгаа хуулиараа зохицуулах боломжтой гэж харж байна.

Б.Тэлмүүн: За гишүүд асуулт асууя?

Г.Алтанзаяа: Үл хөдлөх эд хөрөнгө юм уу?

Магадлагч М.Алтангэрэл: Тийм үл хөдлөх хөрөнгө байдаг юм байна, оффисын барилга, ажилчдын сууц байдаг.

Г.Алтанзаяа: Баланс дээр нь бүртгэл нь яаж явдгийн.

Магадлагч М.Алтангэрэл: Зөвхөн оффисын барилгаа л санхүүгийн тайландаа бүртгэсэн байдаг.

Д.Мөнхтамир: Капитал биш юм байна. Газрын тосны газраас баримт материал авсан юм уу? Жил болгон очиж тайлангаа тулгадаг шиг санаад байна.

Магадлагч М.Алтангэрэл: Татварын хяналт шалгалтын явцад Газрын тосны газраас тодруулга авахаар албан бичиг хүргүүлж байсан байна. Тос хуваалтын талаар ирсэн болгохоос өртөг нөхөлтийн зардал, яаж тооцсон талаар явуулаагүй байсан.

Д.Мөнхтамир: Урд очиж жил болгон тайлангаа тулгадаг, тэрийг авмаар юм байна.

Г.Алтанзаяа: Нэхээд өгөөгүй л байна тийм үү?

Магадлагч М.Алтангэрэл: Тийм, өгөөгүй.

Р.Мягмаржав: Петрочайна компани болохоор гэрээгээрээ бүх татвараас чөлөөлөгдөх ёстой гэдгээрээ яваад, байцаагчийн ногдуулсныг хүлээн зөвшөөрөхгүй гээд байгаа шүү дээ.

Б.Тэлмүүн: Өмнөх Маргаан таслах зөвлөл 2012 онд шийдвэр гаргаж байсан. Тухайн үед шинжээчийн баг гаргуулаад санал, дүгнэлт гаргуулсан байдаг. Санал, дүгнэлт нь товчхондоо ингэж байгаа. "Анх бүтээгдэхүүн хуваах гэрээг АНУ-ын Соко гэх компанитай байгуулж байгаад Дачин тамсаг руу шилжсэн, Дачин тамсаг руу шилжихдээ Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг зөвхөн Засгийн газрын хуралдаанаар зөвшөөрсөн тохиолдолд шилжүүлдэг 1991 оны Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмыг зөрчсөн байна. Үүнээс цааш Засгаас ямар нэгэн шийдвэр гаргаагүй. Татварын хуулиар Засгийн газар хууль тогтоомжоор олгосон бүрэн эрх хэмжээний хязгаарт багтаан тогтвортой байдлын гэрээ, эсхүл хөрөнгө оруулалтын гэрээгээр тухайн гэрээ байгуулах үед мөрдөгдөж байсан татварын нөхцөлийг хадгалах боломжтой байгаа юм. Тэгээд хэдийгээр Засгийн газарт тодорхой төрлийн гэрээ байгуулах эрх буюу тогтвортой байдлын шинж чанартай гэрээ байгуулах эрх олгосон боловч уг гэрээний дагуу татвараас чөлөөлөх эсэх асуудлыг шийдвэрлэх бүрэн эрх УИХ-д байсан. Иймд татвараас чөлөөлөх асуудал Засгийн газрын эрх хэмжээнд байхгүй байсан юм. Харин гэрээ байгуулах үед Засгийн газраас стратегийн хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд татварын хууль тогтоомжийн заалтыг батлагдсанаас хойш татварын хууль, тогтоолын заалт яаж өөрчлөгдөж байгаагаас үл хамаараад тогтвортой мөрдөнө гэсэн байна.

Тэгээд Бүтээгдэхүүн хуваах гэрээг хөрөнгө оруулалтын гэрээний нэг төрөл гэж үзэж болно, Хөрөнгө оруулалт гэрээ нь татварын орчныг тогтвортой байлгах гэж заасан байгаа юм. Харин Газрын тосны хуулиар гэрээлэгчийг татвараас чөлөөлөх асуудлыг зохицуулаагүй байгаа юм, тухайн үеийнхээ хууль тогтоомж зөрчсөн болон Засгийн газрын гэрээлэгчтэй байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ гэж үзээд энэ дээр 2 дүгнэлт хэлсэн байна.

Нэгдүгээрт нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний түрүүний хэлсэн заалтад заасны дагуу гэрээлэгчийн гадаадын оролцон гүйцэтгэгч болон гадаадын ажиллагсад орлогын болон бусад татвараас чөлөөлөгдөхөөр заасан байгаа нь нэг талаас гэрээлэгч гадаадын аж ахуй нэгжид тэр гэрээг ашиглан хуулиас давсан эрх эдлэх боломж олгож байгаа. Гэвч энэ нь гэрээний нөгөө тал болох Засгийн газраас хуулиар олгогдсон эрх хэмжээгээ хэтрүүлэн гэрээ байгуулж, баталгаажуулсан Засгийн газрын гэм буруугийн асуудал үүсэж байна. Хоёрдугаарт, Бүтээгдэхүүн хуваах гэрээний 10.4-ийн "д"-д дэд зааснаар гэрээлэгчийн өмнөөс төлсөн буюу гэрээлэгч төлбөрөөс чөлөөлөгдөх ёстой орлогын орлон төлөх татвар, орлогын татвар, бусад татвар төлөхийг Засгийн газрын аль нэг байгууллага, гэрээлэгчээс шаардвал гэрээлэгч Засгийн газрын төлөөлөгчтэй зөвлөлдөж, энэ шаардлагыг хэрхэх талаар Засгийн газрын төлөөлөгчийн зааврыг дагана. Энэ төлбөрийг гэрээлэгч заавал төлөх ёстой гэж үзвэл гэрээлэгчээс түүнийг төлсөн баримтыг авчран Засгийн газар төлнө гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр юу гээд заачихсан гэхээр Засгийн газрын аль нэг байгууллага мөнгө төлөхийг шаардах юм бол Засгийн газраас асууна гэж байгаа юм. Засгийн газар түүнийг тол гэх юм бол Засгийн газарт баримтаа төлөөд Засгийн газар нөхөн төлнө гэж байгаа юм.

Тэгээд шийдвэр нь "Петрочайна дачин тамсаг" ХХК-д актаар ногдуулсан төлбөртэй холбогдон Монгол Улсын Засгийн газартай холбоотой дээрх 2 асуудал хөндөгдөж байна гээд, иймд Засгийн газрын гэм буруугийн асуудал, хоёрдугаарт актыг эргээд Засаг төлөх юм байна. Тийм учраас Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэн байгуулах, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөлт оруулсны дараа татвар ногдуулах асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзээд актыг хүчингүй болгож байна. Тэгэхээр актыг хүчингүй болгоод гэрээг шинэчлэх тухай саналаа Эрдэс баялаг эрчим хүчний яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Газрын тосны газарт уламжилсан" ийм шийдвэр гарсан байна.

Ерөнхийдөө Засгийн газар бол татвараас чөлөөлөх эрхгүй байсан, гэхдээ Засгийн газрын

байгуулсан гэрээ тогтвортой байдлын хүчин чанарын гэрээний агуулгатай, гэрээний харилцааны дагуу үүргээ хүлээсэн, нөгөө талдаа юу гэж үүрэг хүлээсэн гэхээр мөнгө нэхвэл бид нар өмнөөс нь төлнө гэдэг. Тэгэхээр магадлагч тодруулах шаардлагатай гэвэл бид нарын шийдвэрийн хэлбэр нэг өөр болно. Дахин тодруулах шаардлагатай, магадлан судлах боломжоос хэтэрсэн гэж үзвэл дээд шатны татварын албанд актын биелэлтийг түдгэлзүүлээд нэг удаа буцаахаар Татварын ерөнхий газрын хяналт-шалгалтад дахин хянуулна гэсэн үг үү?

Магадлагч Ш.Цогзолмаа: Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн газар шалгана гэсэн үг.

Б.Тэлмүүн: Нэг ийм санал хураах хувилбар байна, эсвэл актыг хэвээр батлая гэдгийн аль нь яг магадлагчийн санал юм бэ?

Р.Мягмаржав: Сая Б.Тэлмүүн даргын хэлсэн дээр нэг юм асуухад 2012 оны шийдвэр юм байна, тэгээд 2012 онд тийм шийдвэр гаргаад зохих газруудад нь даалгаад чиглэл өгсөн юм байна, тэрнээс хойш гэрээнд өөрчлөлт орсон зүйл байгаа юу?

Магадлагч М.Алтангэрэл: Ороогүй.

Р.Мягмаржав: 2012 оноос хойш, тэгэхлээр дахиад энэ асуудал үүсэх нь байна.

Б.Тэлмүүн: Тухайн үед Сангийн яамнаас ч үүнтэй холбоотой бичиг явуулж байсан юм билээ, би харсан.

Магадлагч Ш.Цогзолмаа: Тийм, холбоотой бичиг явж байсан.

Б.Тэлмүүн: Ийм юм боллоо, энийгээ шинэчлэх шаардлагатай байна гээд Сангийн яамнаас ч, Уул уурхайн яам ч олон удаа хандаж байсан. Энэ гэрээний нөгөө тал чинь Газрын тосны газар байхгүй юу. Би гэрээ шинэчлэх ажлын хэсэгт ороод сонсож байхад үүнээс хойш бол хэд хэдэн удаа оролдлого гаргаад нөгөө тал хүлээж авдаггүй байсан гэж тайлбарлаж байна лээ. Тэгээд гэрээ шинэчлэх тухай Засгийн газрын ажлын хэсэг одоо дахиж гараад ажил нь явж байгаа.

Р.Мягмаржав: Гэхдээ гэрээ шинэчилбэл шинэчилсэн өдрөөсөө хойш явна биз дээ, өөрчлөлт нь.

Б.Тэлмүүн: Тэр нь гэрээний нөхцөл дээр яаж тодорхойлохоос шалтгаална. Магадлагч та 2 хоёул хамт магадалсан бил үү.

Магадлагч Ш.Цогзолмаа: Тийм

Б.Тэлмүүн: Та хоёрын санал түдгэлзүүлээд, нэмж тодруулья гээд байна уу, хэвээр баталъя гэж байгаа юм уу?

Магадлагч М.Алтангэрэл: Хэвээр батлах саналтай байна.

Магадлагч Ш.Цогзолмаа: Миний хувьд нэг тодруулбал яасан юм бэ гэсэн санал байна, хэрэв тодруулах шаардлагагүй гэж үзвэл байцаагчийн акт хэвээрээ.

Б.Тэлмүүн: Санал нь юу юм бэ? Тодруулах шаардлагатай гэвэл наад дүнгүүд чинь эргэлзээтэй гэсэн үг шүү дээ, эргэлзээтэй байна гэж байгаа юм уу, эсвэл дахин нягтлуулах нь зүйтэй гэж байгаа юм уу? 2-өөр шүү дээ

Магадлагч Ш.Цогзолмаа: Яахав, хяналт шалгалтын үед ч гэсэн одоо тодруулаагүй ийм юм байгаа ч гэсэн, байцаагчийн акт хэвээрээ гэж үзэж байгаа.

Б.Тэлмүүн: За оруулж ирэх үү.

Магадлагч Ш.Цогзолмаа: Татварын ерөнхий газрын Маргаан таслах зөвлөл "Петрочайна дачин тамсаг" ХХК-д холбогдох Татварын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсанд гаргасан гомдлыг хянан хэлэлцэж байна. Та бүхэн өөрсдийгөө танилцуулна уу?

Орчуулагч: Петро чайна компанийн санхүү, хяналтын хэлтсийн дарга Го Юн Фен, компанийн хуулийн хэлтсийн дарга хуульч Лин Юи Му, санхүүгийн хэлтсийн дарга нягтлан бодогч Э.Болормаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн Дэгжрэх.

Б.Мөнхлут: ТТТГ-ын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Б.Мөнхлут

Б.Төгсжаргал: ТТТГ-ын ХШХ-ийн татварын улсын байцаагч Б.Төгсжаргал

Ц.Тогосмаа: ТТТГ-ын хуулийн зөвлөх Ц.Тогосмаа

Б.Тэлмүүн: Өнөөдөр танай компанитай холбоотой гомдлыг хэлэлцэж байна, татвар төлөгч болон татварын байцаагч нараас асуух асуултаа зөвлөлийн гишүүд асууна уу? (хэсэг чимээгүй суув)

Б.Тэлмүүн: Татварын байцаагч нараас асууя, яг татварын хяналт шалгалт хийсэн байцаагч нар нь та нар мөн үү?

Б.Төгсжаргал: Үндсэндээ 3 татварын улсын байцаагч томилогдсоноос ганц Б.Төгсжаргал байна.

Б.Тэлмүүн: Би хяналт шалгалтын процесс үйл ажиллагаатай холбоотой асуулт асуух гэсэн юм. Энэ компанид татварын хяналт шалгалт хийхэд процессын хувьд хүндрэлтэй, бичиг баримтын хувьд эсхүл хамтарч ажиллахад гэдэг ч юмуу хүндрэлтэй юм байсан уу?

Б.Төгсжаргал: Анх томилолт өгөөд уулзсан, яг энэ хяналт шалгалтыг хариуцаад анхан шатны баримт өгөх, анхан шатны баримтаас гадна бусад холбогдох гадны байгууллага, дотоодын байгууллагаас нотлох баримтуудаа шаардаж авахад маш их хүндрэл учирсан, бүтэн 1-2 жил энэхүү баримт материалуудаа шаардсан, хоорондоо үл ойлголцсон, энэ асуудал дээр нэлээд хугацаа өнгөрсөн гэж хэлж болно.

Б.Тэлмүүн: Хугацааны хувьд хүндрэлтэй байсан гэж байна, Монгол Улсын Татварын алба хуулиараа хяналт шалгалт хийх бүрэн эрхтэй, Гэтэл хяналт шалгалт нэлээн удсан байсан. Шаардлагатай баримт бичиг гаргаж өгөх хуулиар хүлээсэн үүрэг татвар төлөгчдөд байдаг, гэвч татварын байцаагч нарт удаашралтай, хүндрэлтэй байсан гэж байна, энэ дээр тайлбар хэлнэ үү компанийн зүгээс?

Го Юн Фен: Яг та тухайлаад жишээ, танайх тийм материал нэхсэн чинь удаасан гээд?

Б.Тэлмүүн: Уучлаарай. Маргаан таслах зөвлөл өөрөө хуулиар олгогдсон татварын албаны, сангийн яамны харьяа байгууллага биш, бие даасан байгууллага, хурлын дэгтэй. Энд нээлттэй харилцан яриа явагдахгүй, хурал даргалагч болон зөвлөлийн гишүүдээс та асуусан асуултад хариулна, дараа нь уг хэлэх боломж олдоно.

За би асуултаа өөрчлөөд асууя, татварын хяналт шалгалт хийлгэх явцад татварын албатай үл

ойлголцол, хүндрэлтэй зүйл байсан уу, татварын албаны зүгээс хэлж байгаа дуудахаар ирэхгүй байсан, баримт гаргаж өгөхгүй байсан гэдэгтэй магадлал, гомдол, хариу тайлбарт огт дурдаагүй байна, энэ дээр та бүхний санал ямар байна вэ?

Го Юн Фен: За юуны өмнө хамтарч ажиллах тал дээр хариуцлагагүй байсанд хүлцэл өчье. Яагаад гэхээр энд тухайн шалгалт хийхэд гардаж оролцсон хүмүүс байхгүй байна. Энэ дарга гэхэд 2019 онд ажилдаа томилогдож ирсэн. Тэгэхээр яг энэ дээр хариулт өгөх боломжгүй байна. Тэгээд та бүхэнтэй хамтарч ажиллаж чадаагүй дутуу дулимаг зүйл байсан бол уучлаарай. Одоо буцаж очоод дээшээ уламжилна, тодруулна, дараа дараагийн удаад илүү хамтран ажиллах болно.

Э.Болормаа: Одоо байгаа хүмүүс тухайн үед байгаагүй дандаа шинэ хүмүүс томилогдсон байгаа, тухайн үед яагаад баримт материал гаргахад удсан бэ гэхээр 2014-2017 оны 3, 4 жилийн баримт шалгасан баримтууд нь толгой компани дээрээ, толгой компанийн санхүүгээс урдаас баримт нь ирэх ёстой асуудал байсан. Тэрийг хилээр нааш нь газраар 3, 4 жилийн баримтаа авах гэж их удсан юм байна лээ.

Г.Алтанзаяа: За би нэг асуулт асууя, 1-рт танай компани Монгол Улсын хууль дүрмийг дагаж мөрддөг гэдэг дээр та бүхэн ямар хариулт өгөх вэ? Жишээлбэл нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд баримтжуулалт хийнэ гэдэг дээр, 2-т оршин суугчийн сертификат болон ажил гүйлгээний гэрээнүүд, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ гэсэн ийм зүйлүүдийг нотлох баримтаар ирүүлээгүй гэдгийг татварын байцаагч болон магадлагчийн зүгээс хэлж байна. Энэ ямар учраас эдгээрийг өгч Монгол Улсын хуулийн дагуу явагдаж байгаа энэ үйл ажиллагаанд гаргаж өгч болоогүй юм бэ?

Го Юн Фен: За манай хуульч манайх үйл ажиллагааныхаа явцад бүх үйл ажиллагаагаа хуулийн дагуу явуулж байгаа, манай дээр тулгараад байгаа асуудал бол хууль хэрэгжүүлэхдээ биш, бид нар мэдээж хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа, манай баримталж байгаа гэрээ маань хуультай зөрчилдөж байгаа асуудал байгаад байгаа, аль заалтыг хэрэгжүүлэх нь, бид нар хамгийн эхэнд гэрээгээ баримталж байгаа, хуультай зөрчилдөж байгаа асуудал маш их байгаа учраас энэ их зөрчилдөөнтэй манайд тулгарч байгаа том асуудал юм. Хууль журмыг баримтлах тал дээр бид үйл ажиллагааныхаа явцад баримталж ажиллаж байгаа. 1990-ээд онд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахдаа зарим нэг хуулийн заалттай зөрчилдөж байсан. Тухайн үед манай бүтээгдэхүүн хуваах гэрээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газраас баталсан, заалт нь зөрчилдөж байсан ч гэсэн баталсан, бид нар түүнээс хойш бүтээгдэхүүн хуваах гэрээнийхээ дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Г.Алтанзаяа: Тодруулаад асууя, одоо сая тодорхой зүйл хэллээ, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, сертификат, ажил гүйлгээний гэрээ яг эдгээр зүйлс ямар зүйлтэй зөрчилдөөд шаардсан зүйлсийг гаргаж өгч болохгүй байгаа вэ?

Э.Болормаа: Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гэж ямар гэрчилгээг хэлж байгаа юм бол.

Г.Алтанзаяа: Үл хөдлөх эд хөрөнгө танай дээр байдаг юм уу, балансад бүртгэсэн үү?

Э.Болормаа: Бүртгэлтэй манайх, манай нэг оффис байдаг, гэрчилгээтэй, еер манай дээр бүртгэгдсэн юм байхгүй.

Г.Алтанзаяа: Байцаагч нар ямар гэрчилгээ өг гэсэн юм бол?

Б.Төгсжаргал: 2-3 төрлийн үл хөдлөх хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн татварыг төлөх ёстой байсан ч төлөөгүйд хариуцлага ногдуулсан байна. 1-рт Улаанбаатар дахь оффисын барилга, нөгөөх

нь болохоор Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт байрладаг орон сууцны зориулалттай гэж байгаа, энэ нь бол орон сууцны зориулалтаар ашиглагддаггүй, харин ажилчдыг байлгах зорилгоор үндсэн үйл ажиллагааны удирдлагын зардалд хамаарагдах зориулалтаар ашиглагддаг, 3 дахь нь Дорнод аймагт байрладаг нэгдсэн байгууламж гэдэг хөрөнгө бид татвар ногдуулсан. Энэ дээр газрын тосыг боловсруулахтай холбоотой, ажилчид байрлахтай холбоотой нэгдсэн байгууламж дээр үл хөдлөх хөрөнгийн татвар ногдуулсан. Энийг тус тусад нь үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ аваад ир, зориулалт болгоноор салгаад өг гэхэд нэгдсэн байгууламжаар манайх явдаг гэсэн, татвар төлөгчийн өөрсдийнх нь тодорхойлсон хөрөнгийн үнэлгээгээр татвар ногдуулсан.

Д.Мөнхтамир: За эхлээд хурлынхаа дэгийг барина шүү. Энд орж ирсэн хүмүүс хурлын гишүүдийн асуултад хариулна. Түүнээс биш хоорондоо харилцан яриа явахгүй гэдгийг сануулъя. Үл хөдлөхийн гэрчилгээ гээд байгаа нь татварыг бол ярихгүй, Монгол Улсын хууль дүрмийг биелүүлдэг үү гэж түрүүнд манай гишүүн асуусан, энэ нь тухайн үл хөрөнгийн гэрчилгээ нэгдсэн систем дээрээ авсан уу гэж байгаа юм. Энэний дараа тэр татварын асуудал ярина. Та нар үл хөдлөх гэрээнд хууль зөрчилдөөд байна гэнэ, бүтээгдэхүүн хуваах гэрээнд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ авах энэ талаар юм дурдаагүй байх, тэгэхээр та нар Монгол Улсын хууль дүрмийг биелүүлнэ гэдэг чинь тэр гэрчилгээг аваад энэ нь үл хөдлөх хөрөнгө, энэ нь үл хөдлөх хөрөнгө биш тэр газрын тос боловсруулах газар доорх байгууламж энэ тэр чинь үл хөдлөхдөө орно шүү дээ эд нартаа гэрчилгээ авсан уу, аваагүй бол хуулиа биелүүлж байна уу гэсэн энэ асуудлыг асууж байна.

Э.Болормаа: Улаанбаатарт бүртгэлтэй тэр оффист үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ байгаа, жил болгон татвараа төлөөд явж байгаа.

Д.Мөнхтамир: Үгүй ээ үгүй, татварын асуудал яриагүй, эхлээд зүгээр л тухайн 21, 19 дүгээр талбай дээр байгаа олборлолтын зориулалттай газар доорх байгууламж гээд байгаа ш дээ, морин толгойнуудаас доогуур холбосон баахан труба юмнууд байгаа байх байгууламж, за дээр нь Дорнодод оффисын барилгууд байгаа байх тийм үү.

Э.Болормаа: Оффисын барилгууд нь бүгдээрээ зөөврийн сууцнууд шдээ. Бааз дээр байгаа нь

Д.Мөнхтамир: Сэндвичэн барилга гэсэн үг үү.

Э.Болормаа: 19, 21 дүгээр талбай дээр байгаа тос боловсруулах ТА-1, ТА-2 гээд тос ялгах байгууламж баригдсан юм. Тэр нь бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргаагүй. Одоо ч гэсэн бүрэн гүйцэд баригдаж дуусаагүй.

Д.Мөнхтамир: За ойлголоо, ер нь бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ тэр Дорнодод байхгүй юм байна тиймээ.

Э.Болормаа: Тийм.

Д.Мөнхтамир: Танай удирдлагууд 2019 оноос хойш ирсэн юм байна, 2019 оноос хойш манай магадлагч нар та нартай яриад энэ баримтыг гаргаж өгөөч гэж нэхсэн байна, энийг яагаад гаргаж өгөөгүй вэ? хэрвээ энэ маргаан таслах зөвлөлд нотлох баримтаа ирүүлэхгүй бол бид яаж та бүхний асуудлыг шийдэх вэ? 2019 онд магадлагчид ирсэн тэрнээс хойш хэд хэдэн удаа шаардаад өгөөгүй юм байна. Үүнд тайлбар байна уу?

Э.Болормаа: Яг ямар нотлох баримт юм бол, бид нар уг нь нэхсэн болгоныг бүгдийг нь гаргаж өгч байсан.

Г.Алтанзаяа: Ажил гүйлгээ хийгдсэн гэрээ ерөөсөө ирүүлээгүй гээд байгаа шдээ. Ажил гүйлгээ

хийгдсэн гэрээ та нарт бэлэн байж байгаа шүү дээ. Оршин суугчийн сертификат.

Го Юн Фен: Яг ямар ажил гүйлгээний гэрээ вэ?

А.Энхболд: Та хэдэд нэг юм хэлье татварын байцаагч маш тодорхой юм шаардсан байна. Та нар байхгүй бол байхгүй гэдгээ татварын байцаагчид хэлэх, магадалж байгаа үед мөн байгаа бол байгаа, байхгүй бол байхгүй гэдгээ Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх гээд төрийн албан хаагч очиж байгаа шүү дээ, тэр хүний шаардсан бичиг баримтыг та хэд гаргаж өгөх ёстой юу? Хуулийн дагуух шаардлагад өгөх ёстой. Байхгүй бол байхгүй гэдгээ хэлэх ёстой. Байцаагчдаа очоод юмаа танилцуулах ёстой.

Г.Алтанзаяа: Ямар гэдэг асуудал нь биш, тэр хугацааны хийгдсэн ажил гүйлгээний баримтаа үзүүлж харуулах ёстой.

Б.Тэлмүүн: За би тодорхой жишээ асууя. 2013-2017 онд Америкийн Томсон Найт гээд компанид хуулийн үйлчилгээний төлбөр төлсөн. Үүний гэрээ, төлбөр шилжүүлсэн баримт, нөгөө талын татвар төлөгчийн сертификат зэрэг энэ баримтыг гаргаж өгөөгүй байна. Жишээлбэл, бүтээгдэхүүн хуваах гэрээ бол чөлөөлөлттэй холбоотой асуудлыг зохицуулж байгаа болохоос биш татварын процесс асуудлыг зохицуулаагүй, процесс ажиллагааны хувьд яагаад гаргаж өгдөггүй юм бэ? Монгол Улсын хуулийг үйл ажиллагаа явуулж буй бүх компани дагаж мөрдөх үүрэгтэй байдаг шүү дээ.

Го Юн Фен: Энэ компанийн хувьд манай компани биш энэ төслийн Америкт бүртгэлтэй компани маань энэ компанитай хамтарч ажилласан учраас одоо энэ Тамсагийн төсөлд энэ хоёрын хамаарал Монгол Улсад ерөөсөө үүсээгүй юм аа.

Б.Тэлмүүн: Төлбөр нь Монголоос гарсан юм биш үү.

Го Юн Фен: Энэ бол өртөг нөхөх зардалд ерөөсөө орсон төлбөр биш,

Б.Тэлмүүн: Төлбөр нь Монголын талаас шилжсэн юм уу?

Го Юн Фен: Америкт бүртгэлтэй компанийн Хятад дахь банкны данснаас төлөгдсөн.

Б.Тэлмүүн: Гэхдээ Монголын Петрочайнатай холбоотой үйл ажиллагаа хийсэн үү.

Го Юн Фен: Биш гэнэ. Монголд өртөг нөхөх зардалд ороогүй.

Б.Тэлмүүн: Петрочайн-д дэчин тамсаг компани 2015-2017 онд Томсон компанид хуулийн үйлчилгээний төлбөр хураамж гээд 89 сая төгрөг шилжүүлсэн гээд байна ш дээ.

Го Юн Фен: Монгол дахь компанитай ямар ч хамаа байхгүй, Америкт бүртгэлтэй компани маань өөрөө Америкт бүртгэлтэй хамтран ажиллах гэрээ байгуулаад хуулийн статусын буюу аж ахуйн нэгжийн өөрчлөлттэй холбоотой асуудлаар хуулийн зөвлөгөө мэдээлэл авч ажиллаж байсан. Монголтой бол ямар ч хамаагүй.

Б.Тэлмүүн: Петрочайнагаас гарсан мөнгө юм биш үү. Төлбөр нь эндээс гарсан гээд биччихсэн байна.

Д.Мөнхтамир: Татварын улсын байцаагч энэ дээр тайлбар байна уу.

Б.Төгсжаргал: Өртөг нөхөлтийн тайлан гээд бид нарт цаасан хувь ирүүлсэн. Түрүүн цухас

дурдагдаад байгаа компанийн хувьд зөвхөн ганцхан жишээ нь. Энэнтэй холбоотой өчнөөн үйлчилгээний төлбөр болон бусад төлбөрүүд өртөг нөхөлтийн тайланд зөндөө орсон. Том зардлуудаас нь лавлагаа авах гэхээр Петрочайнатай хамааруулж тухайн үед тайлбар өгч байсан. Манайд нэмэлтээр баримт тайлбар гаргах хүн гараагүй, тэгээд яагаад тэгвэл энэ тайлан дээрээ энэ зардлыг оруулсан юм гэж асуулт тавимаар байгаа юм. Гэхдээ энэ бол хяналт шалгалт биш. Хяналт шалгалтын үед энэ асуултыг зөндөө асуусан. Өртөг нөхөлтийн тайлан гээд хамгийн анх файлаар ирүүлсэн татварын улсын байцаагч энэ дээр ажилласан. Өртөг нөхөлтийн тайлан гээд ирүүлсэн тайланг Хятад хэл дээр, англи хэл дээр ирүүлж байсан. Монгол Улсад монгол хэлээр бичигдсэн баримт бичиг ирүүлэх, орчуулж өгөөчээ, хууль тогтоомж баримтлах талаар удаа дараа хэлсэн. Энэ ажиллагаанд маш их хугацаа алдсан, ажил, үйлчилгээний төрлөөр ангилуулж, хуваалгах процесс ажиллагаа хийгдсэн, ганцхан хурал дээр өөрийн тайлбарлах хяналт шалгалтын явцад өөрөөр тайлбарлах процесс болоогүй. 19 болон 21 дүгээр талбайтай холбоотой бий болсон бүх зардалд орсон тайлан, тайлан тооцоо, зардлуудаа өөрсдөө жагсаалтаар ирүүлсэн байдаг.

Д.Мөнхтамир: За болно.

Б.Тэлмүүн: За энэ дээр тайлбар байна уу. Татварын шалгалт хийх үедээ ирсэн тайлангаар нь хийсэн. Цаад ажил гүйлгээний баримтаа өгөөгүй юм уу

Б.Төгсжаргал: Бүх ажил гүйлгээгээ ангилж ялгаад дотроос нь тодруулж асуусан. Эх үүсвэрийн үндсэн зарчмаа дагаад яг ямар үйлчилгээ, зардал гарсан юм. Гэрээгээ авчир, шаардлага хангуулж Монгол хэлээр авчирч өгөөч гэхээр шаардлага хангуулах байтугай гэрээгээ ч авчирч өгөөгүй, энэ талаараа татвар төлөгч тайлбар өгөөгүй.

Б.Тэлмүүн: За өөр асуулт байна уу.

Б.Болормаа: Татвар төлөгчөөс асууя Татвар төлөгч Маргаан таслах зөвлөлд гаргасан гомдлын 3 дугаарт ингэж бичсэн байна. Татварын шийтгэл оногдуулахад үндэслэл болгосон тоо баримт нь манай санхүүгийн тоо баримтаас илт зөрүүтэй, тоо баримтыг их хэмжээгээр үндэслэлгүйгээр нэмсэн, гадаад валютаар тооцогдох төлбөр баримтыг төгрөгт шилжүүлэхдээ ямар ханшийг үндэслэсэн гэх зүйлийг бичээд олон хуулийн заалт зөрчсөн гэж танай гомдол бичсэн байна. Асуулт нь ямар санхүүгийн баримт материал тайлан тооцоо танайд байгаа юм. Ямар үндэслэлээр их хэмжээний дүнгээр буюу ямар дүнгээр, ямар санхүүгийн тайлан тооцоог илт өндөр дүнгээр зөрүүтэй гэж үндэслээд байна. тооцоо баримт байна уу. Ямар хэмжээний дүн байгаа юм. Юу үндэслээд ингэж маргаж байна. Үндэслэл нь юу юм бэ. Яг гаргаж байгаа үндэслэлээ л товч тайлбарлана уу?

Го Юн Фен: Аудит хийх явцад манай талаас холбогдох материалаа огохгүй байна гэдэг дээр бидний зүгээр аль болох боломжоороо бүх баримтаа өгч байсан. Зарим баримт бичиг, гэрээнүүд маань англи хэл дээр хийгдэг учраас бид Монгол хэл дээр гаргаж өгөхөд цаг хугацаа, хүчин чадлын хувьд боломж хэцүү байсан. Гэхдээ англи хэл дээрх баримтаа гаргаж өгсөн.

Г.Алтанзаяа: Уучлаарай, тодруулаадахъя. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль дээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компани бүх баримт бичгээ Монгол хэл дээр бүх бичиг баримтаа хөтөлнө гэсэн байгаа. Энэ заалтыг танайх мөрдөж ажилладаггүй гэсэн үг үү.

Го Юн Фен: 1990-ээд онд байгуулагдсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд англи хэл дээр хийнэ гэж заасныг баримталж ирсэн. Газрын тосны газар ч мэдэж байгаа. Гэрээн дээр англи хэл дээр байна гэсэн байгаа. Тухайн үед гаргаж өгч байсан тоонууд ерөнхийд нь их дүнтэй тоо жагсаагаад гаргасан байсан. Ийм тоо гаргахаас өмнө ийм тооцоолол гарч байна танайд ийм тооцоолол байна уу гэж тодруулж асуугаагүй, шууд баахан тоо гаргаад ирсэн, бид нар ямар тооцоолол хийснийг мэдэхгүй

учраас гомдолдоо ингэж бичсэн юм.

Б.Тэлмүүн: Татварын байцаагч нараас асуухад сая ч бас хэлж байна, танилцах тайлбарлах боломж өгөөгүй акт гарсан гэдэг асуудал яриад байна. Энэ тал дээр процессыг нь тайлбарлаач, удаа дараа гомдол дээр ч бас дурдагдаж байна.

Б.Төгсжаргал: Анх хяналт шалгалтын томилолт үүссэн цагаас эхлээд яг Петрожайна дачин тамсаг гэдэг компанийн хариуцагч хэн байх вэ, холбоотой тайлан тооцоог хэн гаргаж өгөх вэ, Монголын талаас тайлан тооцоог хаана, хэн гаргах вэ, гаднын харилцагч болон толгой компанийн холбоотой мэдээ тайланг ямар хүн гаргаж өгөх вэ гэдгийг хамгийн анх хяналт шалгалтын төлөвлөлтөө маш сайн хийж орсон учраас хариуцагчаа тодорхой болгохыг эрмэлзсэн. Харамсалтай нь энэ компаниас маш хариуцлагагүй хандаж тайлан тооцоогоо тайлбарлах, зөрчилтэйгөө танилцах, зөрчлөө тайлбарлах хүн хяналт шалгалтын хугацаанд байгаагүй. Харин хяналт шалгалт дууссаны дараа өөрсдийнх нь ирүүлсэн тоо мэдээн дээр ажиллаж байхад ийм тайлбар тавьж байгаа нь маш харамсалтай байна.

Ц.Тогосмаа: Би нэмээд тайлбар хэлж. Тэгэхээр Петрожайна дачин тамсаг компанийн татвар ногдуулалт төлөлтийн байдалд хяналт шалгалт хийх явцад Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны дагуу энэ хяналт шалгалт хийгдсэнээрээ онцлогтой, Татварын ерөнхий хуулийн дагуу хариуцлага оногдуулах заалт Зөрчлийн хуулиар хариуцлага тооцохоор шилжсэн хууль хэрэгжиж байсан учир Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмаар прокурорын хяналт дор хяналт шалгалт хийгдсэн. Прокурор бидний хийсэн хяналт шалгалтыг хууль тогтоомжид нийцэж байна гэж үзээд хянаад буцаагаад хүргүүлсэн. Хэрэв бидний энэ хяналт шалгалтын үйл ажиллагаа хуульд нийцэхгүй байна гэж үзсэн бол хяналтын явцад прокурорт гомдол гаргах эрх нь нээлттэй, прокурор ажиллагааны явцад хийгдсэн эрх бүхий албан тушаалтны үйлдэл хуульд нийцээгүй бол гомдлыг хүлээж аваад шийдвэрлэх боломж байсан. Эрх үүргийг нь зөрчсөн үйлдэл гаргасан бол дээд шатны прокурорт гомдол гаргах хууль хэрэгжиж байсан үед гомдол гаргаагүй, процесс хүчин төгөлдөр болоод өнгөрсөн үед ийм гомдол гаргаж байгаа нь 1 дүгээрт хуульд нийцэхгүй байна. 2 дугаарт нотлогдохгүй байна.

Б.Тэлмүүн: За ойлголоо. Прокурорт бол энэ компани гомдол гаргаагүй юм байна тийм үү.

Го Юн Фен: Манайхаас прокурорт гомдол гаргаагүй, шууд Татварын Маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан.

Б.Тэлмүүн: Маргаан таслах зөвлөлийн хэлэлцэх асуудал, хэлэлцэхгүй асуудал гэж байгаа. Танайхны хэлж байгаа акт үйлдөлтэй холбоотой процессын асуудал ХЭН НЬ Ч ЯРИАГҮЙ, танайхаас хуульч хүн нь мэдэж байгаа байлгүй, тухайн үед өөрсдөө прокурорт гомдол гаргаагүй гэдгийг сайн ойлгуулж хэлээрэй. За өөр асуулт байна уу.

Ц.Тогосмаа: Нэмэлт тайлбар байна.

Б.Тэлмүүн: Болсон. Гомдол гаргагч талаас сая яригдаагүй, гомдолд дурдагдаагүй өөр нэмж хэлэх зүйл байна уу.

Го Юн Фен: Тэгээд 2011 онд үүнтэй адил нөхцөл байдал үүсэж байсан бөгөөд тэр үед Маргаан таслах зөвлөлд гомдол гаргаад маргаан таслах зөвлөлөөс 2012 онд актыг цуцлагдаж байсан. Тэрнээс хойш манай компани Газрын тосны газар, Уул уурхайн яам, Сангийн яамтай гэрээний талаарх, гэрээ болон хуулийн зөрчлийн талаарх, хэрхэн шийдвэрлэх талаар ажлын хэсэг байгуулагдаад ярилцаж байсан, эцэслээгүй, энэ зөрчил одоо хүртэл шийдэгдээгүй болохыг анхаарч үзнэ үү.

Б.Тэлмүүн: Б.Мөнхлут даргаас Хятадтай холбоотой гүйлгээтэй холбоотой суутган татварын тухайд татварын улсын байцаагч Давхар татварын гэрээний дагуу сертификатыг үзэж байсан уу. Акт үйлдэхтэй холбоотой ямар арга хэмжээ авсан бэ?

Б.Мөнхлут: Би тухайн үед шийтгэлийн хуудсыг хянаагүй. Сүүлд томилогдож ирсэн.

Б.Тэлмүүн: Байцаагч хариулт нь уу. Давхар татварын гэрээний талаар.

Б.Төгсжаргал: Ахалж байсан байцаагч Х.Наранчимэг, Т.Баасан бид тухайн үед Хяналт шалгалтын хэлтсийн Ц.Хандаа даргаас тухай бүр арга зүйн зөвлөгөө авч байсан. Анх томилолт үүсэхээс авхуулаад татвар төлөгчийн шаардлагатай бичиг баримтаас хамгийн түрүүнд баримт бичиг, гэрээнүүд, татвар төлөгчийн ажил гүйлгээ хийж байсан сертификатууд гэх мэтчилэн баримтыг шаардсан.

Б.Тэлмүүн: За баримт ирээгүй. Харин актаа үйлдэхдээ ямар арга зүйгээр суутган татвараа тооцож авсан бэ.

Ц.Тогосмаа: "Петрочайна дачин тамсаг" компанийн хувьд Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр хариуцлага ногдуулсан зүйл байхгүй. Суутган татварын асуудал яригдаж байна. Давхар татварын гэрээ бол компанийн гадаадын хуулийн этгээдтэй хийсэн ажил гүйлгээн дээр хийгдсэн ажилд сертификатын дагуу орлогыг чөлөөлөх ажлыг ярина. Суутган татвар бол бусдаас авсан татварыг төлөөгүй гэдгээр тавьсан.

Б.Тэлмүүн: Хятадтай хийсэн ажил үүргийн хувьд суутган татварын асуудал, хэдэн төгрөг авах вэ гэдэг дээр давхар татварын гэрээг хэрхэн хэрэглэсэн бэ.

Б.Төгсжаргал: Үндсэн гэрээний хөнгөлөлт эдлүүлэх нотлох анхан шатны баримт ирээгүй учир хуулийн хувь болох 20 хувийр авсан. Аль улсын татвар төлөгч болохыг нотлох баримтгүй.

Б.Тэлмүүн: Хятадын талгаас Мэдээлэл харилцан солилцох байдлаар Хятадын татварын албанд хүсэлт тавьсан уу.

Б.Төгсжаргал: Албан ёсоор хүсэлт тавиагүй?

Ц.Тогосмаа: Суутган татварын тухайд шууд Хятадын хуулийн этгээд гэж шууд үзэх боломжгүй. Хятадын Канадын аль улсын татвар төлөгч болох нь тодорхойгүй байсан.

Б.Тэлмүүн: Харин тэрийг л мэдээлэл харилцан солилцох журмаар тодорхойлох ажил хийгээд мэдээлэл харилцан солилцоогүй юу? (хариулт өгөөгүй)

Б.Тэлмүүн: За асуулт, санал дууссан бол гараад хүлээж байна уу. Зөвлөлдөж шийдвэр гаргагч гэр.

Б.Тэлмүүн: За гишүүд саналаа хэлье.

Р.Мягмаржав: Шалгалтын явцад байцаагчаас материал шаардаад ирүүлээгүй гээд байна. Мөн гомдол гаргагчаас 2011 онд Маргаан таслах зөвлөлөөс гарсан шийдвэртэй адилхан шийдэгдэх ёстой л гэдэг санааг хэлээд байна.

Г.Алтанзаяа: 2012 онд хүчингүй болгох биш, эсрэгээрээ явсан бол энэ асуудал аль эрт шийдэгдчих байсан юм байна гэж бодож байна.

Б.Тэлмүүн: Бид өмнө нь нэгэнт шийдвэрлэсэн асуудлыг яриад яах вэ.

Р.Мягмаржав: Ерөнхий нягтлан нь тодорхой хариулт өгөхгүй, бүтээгдэхүүн хуваах гэрээгээ ярьчихая л гэж орж ирсэн байна.

Г.Алтанзаяа: Харин юу ч бэлдээгүй, ярьж чадахгүй байна. Зөвхөн гэрээ болон өмнө нь шийдвэрлэсэн 2012 оны Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг л яриад байна.

Р.Мягмаржав: Акттай холбоотой юу ч асуугаад нэмэргүй юм байна.

Тэлмүүн: Одоо 3 дахь асуудал хувь хүний орлогын албан татварын суутгалын асуудлыг ярья. Давхар татварын гэрээтэй холбоотойгоор хилээр орж ирсэн ажиллагсдыг 183 хоногоос дээш, доош хугацаагаар байсан эсэхийг Хил хамгаалах байгууллагаас тодруулж үзэх ёстой байсан байна. Энэ талаарх баримт байдаг уу?

Магадлагч Ш.Цогзолмаа: Тийм баримт байдаггүй.

Б.Тэлмүүн: Энэ талаар шалгаж тодруулахгүйгээр шууд 20 хувиар тооцох нь зөв үү. Ийм байхад магадлагчийн зүгээс актыг хэвээр гэж оруулж ирж байгаа нь зөрчилдөөд байгаа юм биш үү?

Магадлагч Ш.Цогзолмаа, М.Алтангэрэл: Магадалгааны явцад уулзаж, ярилцсан, шаардсан, оршин суугч бусын сертификат, ажил үйлчилгээний гэрээг тодруулах боломжтой байсан юм болов уу? Эдгээр баримтуудыг гаргаж өгсөн бол давхар татварын гэрээ, ямар ажил, үйлчилгээ, 183 хонор гэдэг нь бодитой болж, ямар ч тооцооллын маргаангүй болох юм. Татварын улсын байцаагчид баримт өгөөгүй л гэдэг тайлбар хэлдэг. Татвар төлөгчөөс баримт шаардсанаа бас нотолж чаддаггүй.

Б.Тэлмүүн: Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээртэй холбоотой асуудалд Татварын алба олон талаас нь нухацтай хандах ёстой. Дахин шалгуулахаар буцаавал процессын хувьд боломжтой юу?

Д.Мөнхтамир: Болно. 3 сарын хугацаагаар түдгэлзүүлээд дээд шатны татварын албанд шалгуулахаар буцаах зохицуулалт бий.

Б.Тэлмүүн: Зөрчлийн хуулийн дагуу прокурор хяналт тавьж оролцох уу?

Д.Мөнхтамир: Одоо дахин шалгаад гарах эрх зүйн акт нь процессынхоо дагуу бол нөхөн ногдуулалтын акт үйлдэгдэнэ.

Б.Тэлмүүн: Прокурорын хяналт тавиад гарсан шийтгэлийн хуудас гээд дахиж тэр хэлбэрээр гарахгүй юу?

Д.Мөнхтамир: Процессынхоо дагуу өнөөдөр акт гарах бол нөхөн ногдуулалтын акт үйлдэгдэх учраас татварын хяналт шалгалт буюу нөхөн ногдуулалтын актыг прокурор хянах зохицуулалт байхгүй. Харин хэрэглэх хуулийн хувьд Зөрчлийн тухай хуулийг бариад явна.

Магадлагч Ш.Цогзолмаа: Эрх зүйн байдал дордуулах зохицуулалт байхгүй. Энэ хугацаанд нөхөн ногдуулалт нь торгууль 30 хувь, алданги нь 20 хувиар явах учраас эрх зүйн байдал дордох асуудал яригдахгүй. Харин хэлбэрийн хувьд шинэ үйлчилж буй хуулийн дагуу шийтгэлийн хуудас биш, нөхөн ногдуулалтын акт л үйлдэгдэх юм.

Б.Тэлмүүн: Байцаагчийн актыг шууд хэвээр үлдээхэд учир дутагдалтай, шалгаж тодруулах зүйлүүд байна. Энэ асуудал нь Маргаан таслах зөвлөлийн магадлан судлах боломжоос хэтэрсэн гэж үзэж байгаа учраас актыг 3 сарын хугацаатай түдгэлзүүлээд дахин шалгуулахаар дээд шатны татварын албанд буцаах саналтай байна. Гишүүд ямар саналтай байна вэ? Элчин сайдын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмалын газар, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал даргаас уг асуудлыг шуурхай шийдвэрлүүлэхийг хүссэн бичиг ирсэн байгаа. Гэхдээ Маргаан таслах зөвлөл эдгээр бичгээр шийдвэр гаргахгүй, гэхдээ ийм бичиг ирсэн гэдгийг танилцуулж хэлэх нь зүйтэй байх.

Санал хураах томьёолол дээр саналтай хүн байна уу?

Гишүүд: Байхгүй.

Б.Тэлмүүн: Шалгалтын явцад татвар төлөгч материалаа гаргаж өгөөгүй, хангалтгүй оролцсон, материалаа гаргаж өгөөгүй, үл хүндэтгэсэн байдалтай оролцсон, нөгөө талаар байцаагч ч бүрэн торгуулж, тодруулахгүйгээр шийдвэрлэсэн байдал харагдаж байна. Иймд актыг түдгэлзүүлээд, дээд шатны татварын албаар шалгуулахаар буцаах саналын томьёоллоор санал хураая

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Маргаан таслах зөвлөлийн бүх гишүүд дэмжиж байна. Татгалзсан, түдгэлзсэн саналтай хүн байхгүй, 100 хувийн саналаар шийдвэрлэв.

Б.Тэлмүүн: Шийдвэрийг танилцуулсан нь.

Маргаан таслах зөвлөл нь бие даасан, хараат бус шийдвэр гаргадаг институт. Татварын ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.11 дэх хэсэгт зааснаар гомдлын нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай, асуудлыг дутуу шалгасан, тодруулах зүйлийн цар хүрээ нь Маргаан таслах зөвлөлийн магадлан судлах боломжоос хэтэрсэн гэдэг агуулгаар актыг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлж, дээд шатны татварын албанд буюу Татварын ерөнхий газарт буцааж шийдвэрлэж байна. Энэ хугацаанд татвар төлөгчийн зүгээс хяналт шалгалтын явцад идэвхтэй оролцож, шаардлагатай болон шаардсан баримт материалыг гаргаж өгөхөд онцгой анхаарах шаардлагатай байна. Хяналт шалгалтын явцад өмнөх шиг байдалтай оролцохгүй байхыг анхааруулж байна. Энэхүү Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг танилцуулж байна.

Го Юн Фен: Бидний хувьд маргаан таслах зөвлөлөөс гарч буй шийдвэрийг хүндэтгэн хүлээн авч байна. 3 сарын хугацаанд тодруулах шаардлагатай гэж үзсэн асуудлаар дахин ажиллах болно. Бидний хувьд татварын улсын байцаагчдын гаргасан тоо буюу торгууль, алдангийг яаж тооцсоныг мэдэхгүй байгаа учраас түдгэлзүүлж буй 3 сарын хугацаанд уг асуудлыг илүү сайн тодруулаад тулгаж, ярилцъя. Манай компанийн гол үндсэн баримт бичиг бол Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгаа, үүний дагуу бид татвар төлөх ёсгүй. Тэгэхээр үүнийг баримталж 3 сарын хугацаанд торгуулийн тоо хэмжээний талаар ярилцах болно.

ХУРАЛДААНЫГ ДАРГАЛАГЧ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Хуралдаан 12 цаг 20 минутад дуусав.

Б.ТЭЛМҮҮН

М.АЛТАНГЭРЭЛ